

**ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-36</i>
<hr/>	
<i>1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/</i>	<i>4-34</i>
<i>2. “Ажлын хэсгийн удирдамж батлах, ажлын дэд хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл</i>	<i>34-36</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
10 дугаар сарын 27-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Т.Энхтүвшин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 56 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн;

Чөлөөтэй: Ц.Анандбазар, Ш.Раднаасэд;

Эмнэлгийн чөлөөтэй: Т.Аубакир, Г.Дамдинням, Н.Наранбаатар.

Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга Б.Тулга, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, мөн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат, мөн газрын Техник технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Мөнх-Оргил, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Идэрцогт, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Сугармаа, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Цэвэлмаа, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний

хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Я.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт С.Төрмөнх, Ч.Сарантуяа нар байлцав.

Төсвийн төслийн танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Г.Ганболд, С.Ганбаатар, Ж.Бат-Эрдэнэ, Ж.Батжаргал, Ц.Туваан, Т.Энхтүвшин нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга Б.Тулга, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал Д.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

***Хоёр. “Ажлын хэсгийн удирдамж батлах, ажлын дэд хэсэг байгуулах тухай”
Байнгын хорооны тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Т.Энхтүвшин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хариулж, тайлбар хийв.

Т.Энхтүвшин: “Ажлын хэсгийн удирдамж батлах, ажлын дэд хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуульа.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 4

Бүгд: 9

55.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 36 минут үргэлжилж, 16 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж 62.5 хувийн ирцтэйгээр 12 цаг 32 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Т.ЭНХТҮВШИН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим, 9 цаг 56 минут

ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Т.Энхтүвшин: Байнгын хорооны эрхэм гишүүд дээ, энэ өдрийн мэндийг хүргэж байна. Тэгээд Байнгын хороонд ирсэн гишүүдээ танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Батжаргал, Улсын Их Хурлын гишүүн Батлут, Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн Туваан, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн, Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэл, Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин, Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат гэсэн гишүүд ирсэн байна. Ирц 56,2 хувьд хүрсэн учир хуралдаанаа нээснийг мэдэгдэж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя. 2 асуудал хэлэлцэнэ.

1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль нийгмийн даатгалын 2024 оны төсвийн тухай Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн 2 дахь хэлэлцүүлэг санал дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ гэсэн байж байгаа. Тийм учраас энэ асуудлыг хэлэлцэнэ.

2 дахь асуудал “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” ажлын хэсгийн дэд хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу. Саналтай гишүүд алга байна. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байхгүй учир хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгээ оруулаарай.

Хуралдаанд оролцож байгаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэндээ танилцуулъя. Сангийн сайд Жавхлан. Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны гишүүн Тулга сайд байна уу. Тулга сайд байж байна. Монгол Улсын Ерөнхий аудитор Занданбат, Сангийн дэд сайд Мөнгөнчимэг алга байна. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат алга байна. Үндэсний аудитын газрыг танилцуулъя. Монгол улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Наранчимэг, Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Самбууням, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Энхболд, Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын аудитын удирдлагын менежер Мөнхцацрал, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер Баярмаа, Санхүү-нийцлийн аудитын газрын менежер Хосжаргал, Санхүү-нийцлийн аудитын газрын менежер Чанцалдулам.

Сангийн яам, Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн, Санхүү төсвийн судалгааны газрын дарга Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Сүх-Очир, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чимэдсүрэн, Хууль эрх зүйн газрын дарга Энхболд,

Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Батмөнх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Ичинноров, Санхүүгийн хөрөнгө удирдлагын хэлтсийн дарга Тулга, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг.

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамрах яамдуудыг танилцуулъя. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Баярбат, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ариунсанаа, Барилгын инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Гантулга, Барилгын хөгжлийн төв төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий инженер Алтанхуяг, Барилгын хөгжлийн төв төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Барилга материалын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Батням, Зам, тээврийн хөгжлийн Дэд сайд Халтар, Төрийн нарийн бичгийн дарга Батболд, Авто замын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Сугармаа, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Цэвэлмаа, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Магнайсүрэн, Хүнд үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга Сүхбат, Уул уурхайн бодлогын газрын Техник технологийн хэлтсийн дарга Намчинсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд Ганхүлэг, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Идэрцог, Салбарын хяналтын газрын дарга Санчирдорж, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Наранчулуун, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга Есөн-Эрдэнэ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг

зохицуулах газрын дарга Дондогдорж, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Довчинсүрэн, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Нарантуяа, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Тавинбэх, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Мөнх-Оргил, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны Хилийн боомтын захиргаа, санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Дүгэржав гэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэндээ танилцууллаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайдыг иртэл улсын Улсын Их Хурлын чуулганаар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг эцэслэн батлахаар байж байгаа. Тийм учраас бас саналаа өгчхөөд, эргэж үргэлжлүүлж хуралдуулъя гэсэн ийм саналтай байна Ажлын хэсгийнхэн байж байгаарай. Жавхлан сайдыг иртэл ямар ч байсан түр хүлээгээд байж байя.

Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайдын микрофоныг өгөөрэй.

Б.Жавхлан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлж, экспортыг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж, иргэдийн бодит орлогыг хамгаалахад чиглэсэн бодлого арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Засгийн газраас авч хэрэгжүүлсэн

арга хэмжээний үр дүнд улсын эдийн засаг сайжирч, улмаар урт хугацааны хөгжлийн эхний 10 жилийн зорилт болох шинэ сэргэлтийн бодлого хэрэгжүүлэх боломж бүрдээд байна. Тиймээс шинэ сэргэлтийн бодлогын гол зорилтын нэг болох хот хөдөөгийн сэргэлтийг дэмжихэд чиглэсэн төсөв санхүүгийн багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр ирэх 2024 оны төсвийн төсөлд тусгасан болно. Ирэх 2024 онд үйлдвэржилтийн бодлогын чиглэлээр хэрэгжүүлэх зарим онцлог арга хэмжээг дурдвал.

1.Татвар нэмэхгүйгээр бизнесийн орчин, хөрөнгө оруулалт, хөрөнгийн зах зээл, боловсруулах үйлдвэрийг дэмжсэн төсвийн орлогын суурийг өргөжүүлэх, татварын бодлого хэрэгжүүлэх;

2.Төсвийн хөрөнгө оруулалтыг нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашигтай төслүүдэд хуваарилах, гадаад зээл тусламжийг Усан цахилгаан станц, газрын тосны үйлдвэр зэрэг тэргүүлэх ач холбогдол бүхий бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг санхүүжүүлэхэд ашиглана;

3.Зэс нүүрс, гангийн баяжмал боловсруулах үйлдвэр барих, газрын ховор элементийн олборлолт хийхэд гадаадын хөрөнгө оруулалтыг татахад чиглэсэн арга хэмжээг эхлүүлнэ;

4.Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан хүнсний хангамж, аюулгүй байдал, үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж хүнсний ногоо, газар тариалангийн ажлын явц бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг технологийн парк, мах, ноос, арьс шир, түүхий эд, хүнс, сүү боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хүүгийн татаас мөн Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжиж, ойжуулалтын арга хэмжээний урсгал зардлыг санхүүжүүлэх зэрэг арга

хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Ирэх 2024 оны төсөвт санхүүгийн бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт 7 хувьд хүрч Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 25,3 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлага 27,4 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдалд 2,1 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2,8% болж төсвийн тусгай шах ш хангаж байгаа болно.

Иймд ирэх оны төсвийн төсөлд үйлдвэржилтийн бодлогын чиглэлээр тусгасан арга хэмжээтэй танилцаж Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Т.Энхтүвшин: Жавхлан сайд баярлалаа. Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол улсын ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат танилцуулна. Занданбат даргын микрофоныг өгөөрэй.

Д.Занданбат: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллагаас Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7 болон Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2024 онд нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг гүйцэтгэлээ. Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн

мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэхийг 7 зорилтын хүрээн дээр хянаж, үнэлэхэд аудитын зорилго чиглэсэн.

Төрийн аудитын байгууллага Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан дараах шаардлагад нийцсэн гэж дүгнэж байна. Үүнд:

1. Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1.1 дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн бодлоготой нийцэж байна. Засгийн газрын өрийн үлдэгдэл дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх харьцаа 2024 онд 40,7 хувьд хүрэх төсөөлөлтэй байхаар тооцоолон тусгасан нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3-д заасан төсөв санхүүгийн аюулгүй байдлын бодлогын зохистой харьцаанд байна.

2. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 25 их наяд 289,8 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 34,2%, нийт зарлага 27 их наяд 360,5 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 37%, тэнцвэржүүлсэн тэнцэл 2 их наяд 70,8 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2,8%-тай тэнцэж байхаар төлөвлөжээ.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2%-аас илүүгүй алдагдалтай, 19 дүгээр зүйлийн 19.9-д

2024 онд 2,8%-аас тус тус хэтрүүлэхгүй байх. Төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль эхээс хэтрэхгүй байх, Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60%-аас хэтрэхгүй байх гэсэн төсвийн тусгай шаардлагуудыг хангасан байна.

3. Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг боловсруулахад Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг дараах байдлаар төлөвлөжээ.

Барилга, хот байгуулалтын сайд 2024 оны төсөлд зардал 413,6 тэрбум, Уул уурхайн, хүнд үйлдвэрийн сайд төвлөрүүлэх орлого 426,2 тэрбум төгрөг, зардал 60,2 тэрбум төгрөг, Зам, тээвэр хөгжлийн сайд төвлөрүүлэх орлого 175,3 тэрбум төгрөг, зардал 682,2 тэрбум төгрөг, Эрчим хүчний сайд зардал 359,8 тэрбум төгрөг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд төвлөрүүлэх орлого 54,5 тэрбум төгрөг, зардал 528,5 тэрбум төгрөг. Төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зардлын дүн 2023 оны тодотгосон төсвөөс 381,6 тэрбум тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 2 их наяд 44,4 тэрбум төгрөгөөр төсөвлөгдсөн нь Засгийн газрын 2024 онд нийт албан хаагчдын үндсэн цалинг 10%-аар нэмэгдүүлэх зэрэг бодлого баримталсантай холбоотой байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр нь “Алсын хараа 2050” “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” 2021-2030

онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилго зорилттой нийцэж буй хэдий ч Монгол Улсын 2024 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээнээс Барилга, хот байгуулалтын яам 4, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 11, Зам, тээвэр хөгжлийн яам 5, Эрчим хүчний яам 4, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 1, нийт 25 хөтөлбөр арга хэмжээг тусгаагүй байна.

Үүнд: Барилга, хот байгуулалтын яам Бүгд Найрамдах Польш улсын зээлээр 5 аймгийн төвд бохир ус цэвэрлэх байгууламж шинээр барих төслийг хэрэгжүүлэх, Баян-Өлгий, Дорнод, Говьсүмбэр, Завхан, Увс.

Улаанбаатар хотын гэр хорооллын 55 мянган өрхийг инженерийн дэд бүтцээр хангах төсөл хэрэгжүүлэх. Газар зүйн мэдээллийн системд суурилсан газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг хөгжүүлэх. Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ газар зохион байгуулалтын төлөвлөлт хяналтын системийг хөгжүүлж хэрэглээнд нэвтрүүлэх.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам. Орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан агаарын геофизикийн цогц судалгааны ажлыг гүйцэтгэх. Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн төлөвийн судалгаа хийх. Цагаан суваргын зэс молибдены ордыг ашиглалтад оруулах, Хармагтайн зэс алтны болон Асгатын мөнгөний ордыг ашиглалтад оруулах, бэлтгэл ажил хангах, Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах, Дорноговь аймгийн Хөвсгөл сумын “Гэрэлт говь кокос” металлургийн үйлдвэр, үйлдвэр технологийн парк байгуулах, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Нүүрс баяжуулах үйлдвэр байгуулах ажлыг үргэлжлүүлэх, Гангийн үйлдвэр байгуулах, газрын тос дамжуулах хоолой барих төслийг хэрэгжүүлэх, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэн уул

уурхайн металлурга химийн үйлдвэрийн цогцолбор үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтцийг байгуулах, Дорноговь аймагт “Алтаниширээт” Аж үйлдвэрийн парк байгуулах.

Зам, тээвэр хөгжлийн яам. Ховд-Улаангом чиглэлийн 163 км авто зам барих, Улиастай-Алтай чиглэлийн 42 км авто зам барих, Хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалын бүс нутгуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, жуулчид автомашинтайгаа аялах боломжийг бүрдүүлэх, Олон улс, улс хооронд, орон нутгийн авто замын дагуу 100-200км тутамд үйлчилгээний цогцолбор, амрах талбай байгуулах, Эрдэнэт чиглэлийн Төв аймгийн Жаргалант сумын Жаргалант уулзвараас эхлэлтэй Сэлэнгэ аймгийн Орхон сумын А1001 авто замын Орхон сумын уулзварт төгсөх хатуу хучилттай 100км авто зам барих, Богд Хаан төмөр зам төслийг эхлүүлэх.

Эрчим хүчний яам. Тавантолгой 300мвт-ын цахилгаан станц холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх, Дулааны 3 дугаар цахилгаан станцыг 325мвт-аар өргөтгөх, Багахангайн 300мвт-ын дулааны цахилгаан станцын төслийг үргэлжлүүлэх, Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц төслийг үргэлжлүүлэх.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам. Монгол Улсыг үхрийн цээж, ямааны годрон, үхрийн тархи, сархирагдах өвчингүй тайван байдлыг дэлхийн мал эмнэлгийн эрүүл мэндийн байгууллагаар баталгаажуулах, Мал эмнэлгийн оношилгооны лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, Хүнсний үйлдвэрлэлийн дэмжлэгийг эцсийн үр дүнд чиглүүлж оновчтой болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуй үйлдвэрлэлийг дэмжих, санхүүжилтийн механизм хэрэгжүүлэх, Нэмэгдсэн өртгийн албан татварын

системд тулгуурлан хүнсний бүтээгдэхүүний хангамж, аюулгүй байдлыг хянах, бүртгэх, дэмжлэгийг оновчтой болгох, цахим системийг хөгжүүлэх зэргээр тусгагдаагүй байна.

Тус байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 оны төсвийн багцад нийт 1 их наяд 320,3 тэрбум төгрөгийн 311 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 461,9 тэрбум төгрөгийн 168 төсөл арга хэмжээ тусгагдсан, 858,4 тэрбум төгрөгийн 143 төсөл арга хэмжээ тусгагдаагүй байна. Үр дүнд чиглэсэн төсөвлөлтийн аргыг улсын болон орон нутаг мөн салбарын төсөвлөлтөд хэрэгжүүлснээс бий болох үр өгөөж, ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор хэмжих үзүүлэлтийг тодорхой болгож хүрэх үр дүнг богино, дунд хугацаагаар тодорхойлж үйл ажиллагааг хэмжэсэнээр төсвийн зардлын ашиглалт, үр өгөөж нэмэгдэж, төлөвлөсөн хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх боломжтой байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд хийсэн аудитын дараах дүгнэлтийг танилцуулж байна. Үүнд:

1.Төсвийн төсөл макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд эрдэс баялгийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ татварын орлого зэргийг өөдрөгөөр төсөөлсөн нь төсвийн орлогын гүйцэтгэлд эрсдэл үүсвэл төсөвт тодотгол хийх нөхцөлд хүргэж болзошгүй байна.

2.Төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн төслийг боловсруулахдаа хөтөлбөр бүрийн өртгийг тооцоогүй арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйцээр бодитой тодорхойлоогүйгээс төсвийн зорилго

хангагдах эсэхийг үнэлэх боломжгүй байна.

3.Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний саналыг эрэмбэлэх, Эдийн засаг, нийгмийн ач холбогдол, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан эдийн засгийн бодит үр өгөөжийн тооцоо судалгаа хийх аргачлалыг боловсруулан баталж, Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.11 дэх заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4.Гадаад өрийн төсөвт үзүүлэх ачааллыг бууруулах зорилгоор дотоод үнэт цаас гарган төсвийн алдагдлын тодорхой эх үүсвэрийг бүрдүүлэхээр төсвийн төслийг боловсруулсан боловч түүний үр ашгийг нарийвчлан тооцоолоогүй байна.

5.Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний барилга байгууламжийн ангилалд магадлал хийгдэж байгаа 21, 1 маягаар болон жишиг магадлалтай 153 төсөл арга хэмжээг тус тус тусгасан байна.

6.Барилга байгууламжид зураг төсөл, магадлал хийх, худалдан авах ажиллагаа зохион байгуулах, гэрээ байгуулах., захиалагчийн хяналт болон гэрээний хэрэгжилтийг хангуулах, Улсын комисс барилга байгууламжийг хүлээн авах зэрэг төсвийн хөрөнгө оруулалтын үйл явцад тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулан субъектив сөрөг нөлөөллийг бууруулах эрх зүйн тодорхой нарийвчилсан зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэнд дараах асуудлыг толилуулж байна. Төсвийн тухай хуулийг хэлэлцэн батлахдаа улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг тухайн

жилийн төсөвт бүрэн тусгуулахад анхаарах. Монгол Улсын Засгийн газар дараа оны төсвийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барихдаа Төрийн аудитын байгууллагаас өгч буй дараах зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна. Үүнд:

Монгол Улсын төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн барихдаа төсвийн төсөл боловсруулах, тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэсэн байх, Улсын хөгжлийн жилийн бодлогын баримт бичигтэй нийцсэн, зөвхөн төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээг төсвийн төсөлд тусгаж байх, Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн дүнд өөрчлөлт орж буй шалтгаан нөхцөлд нарийвчилсан судалгаа, дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч ажиллах, Барилга байгууламжид зураг төсөл магадлал хийх ажлыг зохион байгуулах, худалдан авах үйл ажиллагаа гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулах, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх, Улсын комисс хүлээн авах үйл ажиллагаанд субъектив сөрөг нөлөөлөлгүй байлгах тодорхой нарийвчилсан эрх зүйн зохицуулалтыг бий болгох.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-д заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх чиглэлийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгч, хэрэгжилтэд нь хяналт тавих, хөгжлийн бодлогод нийцүүлсэн үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг бүрэн хэрэгжүүлж, салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан албан хаагчдыг нэгдсэн арга зүйгээр хангаж, чадавхыг нь сайжруулах зэрэг болно. Анхаарал тавьсанд баярлалаа.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Хууль санаачлагч болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчаас асуулт асуух гишүүд байна уу. Гишүүд нэрээ өгье. Туваан гишүүнээр тасаллаа. Батлут гишүүн.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. 2024 оны төсөвтэй холбоотой асуудал дээр аудитын тайлан гарч сая Ерөнхий аудитор бас танилцууллаа. Үүн дээр уул уурхайн бүтээгдэхүүний үнийг нэлээн өөдрөгөөр төсөөлж авсан байна. Энэ нь өөрөө төсөв тасрах, цаашилаад төсвийн тодотгол хийх болзошгүй нөхцөл байдалд хүргэж байна гэж дүгнэчихсэн байна. Тэгэхээр Сангийн сайд энэ тал дээр бас нэг тайлбар өгөөч. Мэдээж 2024 онд манай голлох уул уурхайн бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр ямар байхаар ер нь прогноз гарч байгаа юм. Бид нар одоо ямар хэмжээгээр төлөвлөхөөд байгаа юм. Ямар хэмжээнд өсөлттэй бууралттай байх юм бэ. Тэгээд төсвийн тодотгол хийхгүйгээр явах боломж бололцоо чинь байгаа юм уу. Төсөв тасрах нөхцөл байдал үүсэх үү гэдэг болгоомжлол хэр бодитой юм бэ гэдэг талаар нэг хариулт өгөөч ээ.

2 дугаарт нь 2024 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын ажлууд дээр шилжих ажлууд дээр нэлээн их асуудлууд байна гэж гишүүд ярьж байгаа. Зарим нэг ажлууд тухайлах юм бол 3, 4 жилийн өмнө төлөвлөгдөөд, төсөвт суугаад явсан. Тэр төлөвлөгдсөн, төсөвлөгдсөн зардлаасаа даруй 10 гаруй, 12, 13 дахин илүү өндөр үнэтэй магадлан хийлгэж орж ирсэн байна гэж. Тэгэхээр энэ асуудал дээр ер нь холбогдох мэргэжлийн байгууллагууд юу гэж үзэж байгаа юм бэ. Энэ өөрөө бодитой нэмэгдэл болж чадаж байгаа юм уу. Яг зах зээлийнхээ зарчим, үнэ хани, тарифаараа ингээд бодож үзэхэд энэ 12, 13 хувиар 12, 13 дахин нэмэгдэх нөхцөл байдал үүсчихсэн юм уу. Барилгын салбар дээр, бүтээн байгуулалтын салбар дээрээ. Би зүгээр

яах вэ, бодож л байна л даа. Тэр Ховд аймагт билүү 3 жилийн өмнө 75-100 сая төгрөгөөр 1 багийн байр барьж байсан бол, энэ жил 850 сая төгрөг гээд ороод ирчихсэн байна гээд гишүүд ярьж байна лээ. Тэгээд ингээд бодоод үзэх юм бол бид нар яг хэнд итгэх, төсвөө бүрдүүлэхдээ юунд ач холбогдол өгөх вэ гэдэг дээрээ ер нь анхаарч чадахгүй яваад байгаа юм болов уу гэж харагдаж байгаа.

Энэ магадлан итгэмжлэл гаргаж байгаа, дахин үнэлгээ гаргаж байгаа гэсэн хэсэг мэргэжлийн мафийнхны гар хөл, аманд орчихоод, багтчихаад яваад байгаа юм биш биз дээ бид нар. Энэ тал дээр шалгаж нягталж үзсэн, яг төсөвт өртгөөрөө зах зээлийнхээ үнээр явж байгаа гэдэг дээр үнэлгээ хийсэн мэдээлэл, кэйс байна уу. Тийм юм байгаа бол энэ дээр яг бодитой надад, гишүүдэд бас танилцуулга өгөөч гэж. Энэ хэдэн төсөл арга хэмжээ яг тийм зүйл байгаа бол хэдэн төсөл арга хэмжээн дээр хэчнээн тэрбумын илүү тийм тооцсон, гаргасан зардал байгаа юм бэ. Энийг яг тоо баримттай нь нэг хэлж өгөөч ээ.

3 дугаарт нь манай Орхон аймаг дээр хамгийн анхны сургууль гээд 3 дугаар 12 жилийн сургуулийг буулгаж барих ажил эхэлсэн. 2020 онд эхэлсэн. Тэгээд энэ ажлыг эхлүүлээд 3 жил гаран болж байна. Одоо 4 дэх жил рүүгээ орох гэж байна. Эхний жил нь 1 тэрбум төгрөг, 2 дахь жил нь 2 тэрбум төгрөг, ирэх онд 3 тэрбум төгрөг тавьж байх шиг байна. Уг нь бүгдээрээ энэ сургуулийг дуусгачихъя гэж зарчмын хувьд тохирсон санагдаж байгаа. Дээрээс нь сая өнгөрсөн сар Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүрэлдэхүүнтэйгээ Орхон аймагт ажиллахдаа иргэдийн уулзалт дээр 3 дугаар сургуулийн барилгыг бүрэн дуусгана гэж хэлсэн.

Т.Энхтүвшин: Хэн хариулах вэ. Жавхлан сайд, дараа нь нэмээд яачих. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Батлут гишүүний асуултад хариулъя. Батлут гишүүнтэй тэр болгоомжилж байгаа зүйл дээр би 100 хувь санал нийлж байна. Манай Монгол Улс ер нь уул уурхайгаас хамааралтай ийм төсөв эдийн засгийн бүтэц рүү ер нь 10 хэдэн жил өөрийн эрхгүй ингээд яваад орчихсон. Энэ өсөлт эдийн засгийн тэлэлт бол яг маш эмзэг ийм шаазан шиг л юм байгаа юм шүү. Хэт их савлагаатай тэгээд бид үнэнд нь нөлөөлж чадахгүй дэлхийн зах зээлээс шалтгаалдаг гадаад хүчин зүйлээс нөлөөлдөг хэт хамааралтай ийм эдийн засаг руу яваад орчихсон. Тийм учраас хэт энэнд найдаж ингэж эдийн засгаа чиглүүлэх бол маш аюултай. Хэзээ нэг өдөр ийм тогтворгүй, ийм савлагаатай эрсдэл рүү орохыг үгүйсгэхгүй. Тийм учраас би НӨАТ-ыг хамгаалж том бодлогоо яриад байгаа юм. Монгол Улсын төсвийн нийт орлогын 28%-ийг дангаараа бүрдүүлдэг болчихсон, жил ирэх тусам тогтвортой өсдөг ийм орлого юм байгаа юм. Бид ийм тогтвортой орлогоо бодлогоор хамгаалж, энийгээ олон нийтэд зөв ойлгуулж, хүлээн зөвшөөрч, ингэж явах хэрэгтэй юм байгаа юм. Хойтон жилийн үнийн төсөөлөл бол ийм байгаа шүү Батлут гишүүн ээ, Аудитынхан ямар дүн, үнэ бодоод олчихсон юм би ойлгосонгүй. Бид орлогоо төлөвлөхдөө тэнцвэржүүлсэн үнэ гэдэг юмаараа төлөвлөдөг юм шүү дээ. Тэрийг манай аудитынхан мэднэ биз дээ. Энэ дээр чинь байгаа энэ үнэ чинь зах зээлийн үнэ. Жишээ нь зэсийг 9 мянга гээд тавьчихсан байгаа чинь бол зах зээлийн үнэ шүү. Төсвийн орлогоо тавихдаа бид нар тэнцвэржүүлсэн дүн гэж ийм дүнгээр авдаг. Тэр дүн нь 7.386. Ингээд бид нар багаар нь авдаг. Зэс дээр жишээ нь. Нүүрс дээр одоо зах зээлийн үнэ 140, харин тэнцвэржүүлсэн үнэ 182 байгаа. Бид багаар нь 140-өөр нь авдаг. Тэнцвэржүүлсэн үнэ, зах зээлийн үнэ 2-ын аль багаар нь авдаг гэсэн үг байхгүй юу. Бид ийм хуультай. Энэ хуулиараа ингээд орлогоо тооцсон байгаа юм. Аль

болох эрсдэл багатайгаар ингээж авсан гэсэн үг.

Хэмжээний хувьд бол бид ухралт хийж болохгүй ээ. Бид энэ жил 60 саяар бүр дээшээ гарах гэж байна шүү. Хойтон бид нар энэ жил гаргасан шигээ гаргаж чадахгүй. Уучлаарай ард түмэн ингээж бид тэгэх ёсгүй шүү дээ. Тийм байж болохгүй. Ядаж энэ жил гаргасан биет хэмжээгээрээ гаргаад ингээд зах зээлийнх нь бага үнээр тэнцвэржүүлснийх нь аль бага үнээр нь орлогоо тооцоолж аль болох эрсдэлгүй байхаар ингээж даруухан төлөвлөж орж ирсэн тоо юм байгаа юм. Ноднин бид 2023 оны төсвийг оруулж ирж байхад бас л ингээж зэмлүүлж байсан. Өнөөдөр гүйцэтгэл ямар байгааг та бүхэн харж байгаа байх. 2 ч удаа бид тодотгол хийсэн. Тодотгол хийсэн дүнгээсээ дээд хэмжээгээр экспортууд маань давчихсан ингээд явж байгаа.

Бид боомтын сэргэлтийн бодлогын үр дүнд, Боомтын сайдтай болсны үр дүнд хилийн нэвтрэн өнгөрүүлэх чадвар маань бол эрс сайжирсан байна. Биет хэмжээгээр бол ийм хэмжээний экспорт хийж чаддаг болчихжээ гэдгийгээ харуулчихсан учраас бид нар дор хаяж энэ хэмжээнээсээ гаргаад, энэ хэмжээнээсээ давуулж ажиллах ийм амбицтай байгаа гэсэн үг Засгийн газар. Тийм учраас орлогыг бол бид аль болох даруухан төлөвлөж байгаа шүү. Аудитынхан ямар дүн харж ярьсан тэрийгээ нэг залруулаад хэлчээрэй.

Тэр магадлан хийгдэж байгаа дүнгүүд дээр бол тантай санал нийлж байна. Тийм учраас бид нар шат хүнд сурталтай ч гэсэн дахиад нэг шат тавьчихаад байгаа байхгүй юу. Шууд магадлангийнхаа үнийг авахгүй.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Жавхлан сайдын микрофоныг 1 минут сунгая.

Б.Жавхлан: Тийм учраас бид нар аудитынханд хүсэлт тавиад энийг дахиад аудитлаад өгөөч гээд ингээд явуулаад байгаа юм. Зүгээр аягүй хүнд сурталтай байгаа харагдаж байж магадгүй. Гэхдээ ингээд дахин дахин магадлахаас өөр арга байхгүй. Энд бид чинь ерөөсөө нөгөө цэцээс дээш хөх тэнгэр л байдаг гэдэг шиг яг үнэндээ бол ийм л хуулийн хязгаарлалтад орчихоод байгаа юм. Барилгын материалын үнэ дээр жишээ нь Барилга хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв, Зам, тээврийн хөгжлийн төв гээд 3 хараат бус бие даасан ийм мэргэжлийн институт, тэнд мэргэжлийн үнэлгээчид суугаад яг энэ үнэлгээнүүдийг эцсийн байдлаар гаргадаг юм байгаа юм. Одоо гишүүд өчигдрөөс яриад байгаа хэд хэдэн тэр төслүүд дээр Барилгын материалын төвийнхөн яг өөрсдөө сууж байгаад хариулчихмаар байгаа юм. Бид нар ийм ийм учиртай, ингээж хийсэн гээд. Тэрийг бол бид өмнөөс нь тайлбарлаж үнэндээ чадахгүй. Аль болох л.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн хэддүгээр микрофон вэ. 3 дугаар микрофон. Барилгын хөгжлийн төв. Барилгын хөгжлийн төвөөс хүн байна уу. Төрийн нарийн бичгээ дууд, Сайдаа дууд, Барилгын хөгжлийн төвийнхөө даргыг дуудаадах одоо. Төрийн нарийн бичгийн дарга. 1 дүгээр микрофон.

Ц.Баярбат: Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Баярбат. Батлут гишүүний асуултад хариулъя. Ер нь ковидын нөхцөл байдалтай холбогдуулаад барилгын үнийн өсөлт бол явагдсан. Бараг 70-80 хувийн ийм өсөлт тухайн үедээ хийгдсэн. Ковидын нөхцөл байдал арилснаас хойш үнүүд бол эргэж бууж байгаа. Гэхдээ бид нар бол одоо гол нь манай барилгын материал дээр нөлөөлж байгаа юм бол эм импорттой холбоотой барилгын материалуудын өсөлт байгаа. Энэ дээр бид нар анхаарал хандуулж аль болох дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх

чиглэлээр бид нар ажиллаж байна. Энэ чиглэлээр сүүлийн үед бол дотоодын үйлдвэрлэлүүдийг нэмэгдүүлэхэд 40 орчим хувийн нэмэгдэл ярьж байгаа.

Барилгын объект дээр манай дээр бол Боловсрол, шинжлэх ухааны яамны захиалгатай ажлуудын магадлалууд ер нь түлхүү хийгдсэн. Эндээс бид нар хамгийн сүүлийн байдлаар бол нийтдээ 34 объект дээр магадлалын дүгнэлт гаргасан байгаа. Магадлалын дүгнэлтийг хийхдээ энэ онд бол ерөөсөө үнийн өсөлттэй холбоотой магадлал хийгдээгүй, дандаа нэмэлт ажлууд гарч байгаа ажлуудыг зураг төслийг нь үндэслэж магадлал хийгдсэн байгаа. Энэ бол тухайн объектынхоо хүчин чадал хэмжээнээс хамаараад янз бүрийн дүнтэй нэмэгдэж байгаа ийм асуудлууд бий. Энэ дээр тухайлбал, 500-аас 1 тэрбум хүртэл төгрөгийн хөрөнгө оруулалтын нэмэгдсэн төсвүүдийг бол хянагдсан ийм байгаад байгаа юм. Магадлал хийхдээ бол манайд мэргэшсэн зөвлөх, экспертүүд бол магадлалыг хийж байгаа. Магадлалыг хийхдээ нэгж өртгийн төсвийн норм дээрээ үндэслэж хийж байгаа. Тэгэхээр энэ бол яг батлагдсан нормоороо барьж хийдэг учраас энэ дээр бол магадлалын дүгнэлтүүд нь баталгаатай гарч байгаа гэж ингэж бид нар үзэж байгаа. Үүний дараа бол Сангийн яаманд хүргүүлээд аудитаар хянагдсаны дараа төсөвт орж тусгагдаж байгаа ийм байгаа.

Би тодорхой жишээ объект дээр хэлье. Тухайлбал, Улаанбаатар хотод 960 суудалтай хүүхдийн сургууль гэхэд 6 тэрбум 200-аар тусгагдсан төсөв маань сүүлд магадлалын дүгнэлтэд 1,3 тэрбумаар нэмэгдсэн ийм жишээтэй тодорхой жишээ дүгнэлтүүд бол гарсан зүйлүүд бол байна.

Т.Энхтүвшин: Тодорхой хариулах хэрэгтэй байна даа. Батлут гишүүн хариулт. Үндэсний аудитын газар 3 номерын микрофон, дараа нь Барилгын хөгжлийн төв хариулаарай.

Д.Энхболд: Батлут гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал Энхболд байна. Улсын Их Хурлын 72 дугаар тогтоолоор барилгын материалын үнээс бусад төсөвт өртгийн нэмэгдэл дээр аудитын дүгнэлт гаргах ийм чиглэлийн дагуу Үндэсний аудитын газарт Сангийн яам болон холбогдох байгууллагаас 480 төсөл арга хэмжээний магадлалын дүгнэлтийг хэр үндэслэлтэй байна вэ гэдэг дээр дүгнэлт гаргахаар материалыг ирүүлсэн. Одоогийн байдлаар 283 төсөл арга хэмжээг бол хянаж, дүгнэлтийг хүргүүлээд байгаа. Магадлалын нийт 283 төсөл арга хэмжээнээс Үндэсний Аудитын газар дахин тооцооллыг нь хянаад, нийтдээ 78 тэрбум төгрөгийг бол магадлалын дүгнээс бууруулсан байгаа. Таны тодорхой асууж байгаа багийн барилга байгууламжтай холбоотой төсөвт өртгийн нэмэгдлийг хянуулахаар Үндэсний Аудитын газарт төсөвт өртгийн нэмэгдэл дээр ирүүлээгүй. Энэ дээр бол холбогдох байгууллагууд нь хариултаа өгөх байх.

Т.Энхтүвшин: Сангийн Жавхлан сайд.

Б.Жавхлан: Тэгэхээр төсвийн сахилга батын асуудлыг ярьж байгаа нь их зөв. Төсвийн сахилга бат бол яг эндээс эхэлнэ шүү. Бүгдээрээ яг заалнаас эхэлнэ. Улсын Их Хурлын гишүүд тус бүр бүгдээрээ маш хариуцлагатай байх хэрэгтэй. Та тодорхой төсөл асуугаад байгаа учраас би хэлэхээс өөр арга байхгүй. Ховд аймгийн Буянт багийн төвийн барилгын ажил нь 2020 онд анх зураг төсөвгүй баталсан Улсын Их Хурал. Хойноос нь зураг төсөв яригдаж, магадлан хийгдсэн. Бүр 2022 оны 10 дугаар сард шүү. Ийм байсан учраас 2023 оны буюу энэ жилийн төсөвт бид ноднин өргөн бариагүй. Улсын Их Хурал дээр орж батлагдсан. Анх зураг төсөвгүй тэр хямдхан хаанаас ямар цээжээр тоо тавьчихсан юм мэдэхгүй. Магадлал нь хийгдсэн чинь 800 хэд гээд гараад ирсэн

байна лээ. Энэ жил өргөн бариагүй байсан боловч төсөвт ингээд орчихсон. Би яг үнэнийг нь хэллээ шүү.

Т.Энхтүвшин: Хэн нэмж хариулах вэ. Барилгын хөгжлийн төвийн хүн байна уу. Чи тэр микрофон дээр очоодхооч. Тэр барилгын хөгжлийн төвтэй холбоотой асуудал асуугаад байна шүү дээ. Барилгын хөгжлийн төв. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон. Өөрийгөө танилцуулаад.

Д.Батням: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Намайг Батням гэдэг. Барилгын хөгжлийн төвийн Барилга барилгын материал үйлдвэрлэлийн хэлтсийн дарга албан тушаалтай. Амарсанаа захирал өвчтэй байгаад байгаа юм. Эмнэлэгт байгаа юм. Өвчтэй байгаа учраас...

Т.Энхтүвшин: Барилгын хөгжлийн төвийн дарга Амарсанаа билүү. Даргаа дуудчих. Ганболд гишүүн. 3 хөгжлийн төвийн дарга, Эрчим хүчний хөгжлийн төв, Барилгын хөгжлийн төв, Зам тээврийн хөгжлийн төвийн даргыг дуудъя.

Г.Ганболд: Зам, тээврийн хөгжлийн сайдаас нэг юм асууя. Энэ жил Авто замын сангийн....

Т.Энхтүвшин: Батлут гишүүн тодруулаад асуучих. Батлут гишүүн.

Д.Батлут: Одоо ингээд хэнд нь итгэхэд ойлгомжгүй болчихож байгаа биз. Барилгын яамныхан болохоор яг төсөвт өртгөөрөө асуудалгүй мэргэжлийн экспертүүд гараад ингээд магадлан хийгээд явж байгаа гэж байгаа. Тэгээд нийцлийн аудит хийнгүүт 283 төсөл арга хэмжээнээс 78 тэрбумыг бууруулчихсан гээд гарчихсан. Үгүй, энд чинь хулгай явж байгаа байхгүй юу нөхөд өв. Яг үнэндээ бид нар тэр нөгөө магадлан итгэмжлэл гаргадаг мэргэжилтнүүд нэртэй мафийн гарт орчихоод байна. Энэ дээр шалгалт оруулах

эрхтэй Улсын Их Хурлаас. Бүр тодорхой удирдамж гаргаад, тодорхой чиглэл гаргаад гишүүдийг бүрдүүлж байгаад шалгалт оруулж, энэ хөгжлийн төв, магадлан итгэмжлэл гаргадаг хүмүүстэй холбоотой асуудал, үйл ажиллагаатай холбоотой асуудлыг нягтлан шалгах ёстой. Тэгж байгаад дүгнэлт гаргаж байж, дараа нь энэ асуудлуудыг гаргаж тавих ёстой гэж бодож байгаа юм.

Бас нэг асуултдаа хариулт авч чадсангүй. Тэр 3 дугаар сургууль. Ахиад 1 минут сунгаж өгье дарга аа.

Т.Энхтүвшин: Батлут гишүүний микрофоныг 1 минутаар сунгая.

Д.Батлут: Тэр 3 дугаар сургуулийн хүүхдүүд 400 гаруй хүүхэд 2 хуваагдсан байгаа. Нэг хэсэг нь буюу 400 гаруй хүүхэд склад байр байдаг байранд хичээллэж байгаа юм. Өвөлдөө даарч байна. 3 жил боллоо. Тэгээд 3 жил дусааж, дусааж тавиад, 6 тэрбум төгрөг л тавьчихаад, үлдсэн мөнгийг нь тавиагүй байна. Үгүй ээ, хүүхдүүд хохироод байгаа байхгүй юу. Уг нь Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүрэлдэхүүнээрээ Орхон аймагт ажиллахад иргэдийн уулзалт дээр энэ асуулт асуугдсан. Энэ жилдээ, ирэх ондоо багтаад дуусгана гэсэн. Тэгээд тавьж байгаа мөнгө нь 3 тэрбум гаруй төгрөг л тавьчихаад байгаа юм. Үгүй ээ, энэ дээр ер нь ямар арга хэмжээ авъя гэж бодож байгаа юм бэ. Бид нарт боломж бололцоо байгаа байхгүй юу. Тэр боломж бололцоогоо гаргаж ирж чадахгүйгээр бид нар ингээд хүүхдийн эрхийг зөрчөөд, хүүхдүүдээ үнэхээр зориулалтын бус хүйтэн газар ингээд хичээллүүлээд.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн хэн хариулах юм. Барилга, хот байгуулалтын яам хариулах юм уу. Сангийн яам. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон. Дараа нь үргэлжлүүлээд

Барилга, хот байгуулалтын яам хариулаарай.

Ч.Чимидсүрэн: Батлут гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чимэдсүрэн. Орхон аймгийн Баян-Өндөр сумын 3 дугаар сургууль гүйцэтгэгч нь бол Уранхангай групп байгаа. Тэгээд 2022 онд болбол 8,2 тэрбумын төсөвт өртөгтэйгөөр бол эхэлсэн. Мөн 2023 онд бол Үндэсний аудит руу 8,9 тэрбумын төсөвт өртгийн нэмэгдлээр явуулж баталгаажсан байгаа. Тэгээд нийт 16,4 тэрбумын төсөвт өртөгтэй. 2024 онд бол 3,1 тэрбумын санхүүжилт тавигдсан байгаа. Ингээд 2025 онд 10 тэрбум санхүүжигдэхээр, шилжихээр байгаа. Тэгээд Батлут гишүүн бол энэ онд яагаад гүйцэд тавьсангүй гэсэн асуудал ярьж байна. Энэ ажлын гүйцэтгэлийн явц нь дөнгөж 5,9 хувийн гүйцэтгэлтэй яваа учраас бид нар гүйцэтгэлтэй нь уялдуулж шилжих хөрөнгө оруулалтаа тавьсан байгаа.

Т.Энхтүвшин: Барилга, хот байгуулалтын яам.

Ц.Баярбат: Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүрэг гүйцэтгэгч Баярбат. Батлут гишүүний асуултад хариулъя. Ер нь бол ерөөсөө зураг төсвийн үнийн нэмэгдэлтэй холбоотой асуудлууд, барилгын зураг төсөлтэй л холбоотой. Зураг төсөл дээр ямар нэмэлт ажлуудыг боловсруулж гаргаж ирсэн тэр дээр төсвийн экспертүүд өөрсдөө төсвөө зохиож дүгнэлтээ гаргаж байгаа ийм л арга хэмжээ байгаад байгаа юм. Энэ дээр бол батлагдсан норм байгаа учраас тэр нормын дагуу л хийгдэж байгаа учраас энэ дээр бол бидний зүгээс ямар нэгэн асуудал гарч байгаа гэж бол үзэхгүй байгаа.

Т.Энхтүвшин: Үндэсний Аудитын газар. Үндэсний аудитын газар. Батлут гишүүний микрофоныг 1 минут сунгая.

Д.Батлут: Асуудал үүсэнгүүт ингээд эзэн холбогдогчгүй болчих вий дээ. 2 бие дээ чихээд. Барилгын хөгжлийн төв. Дээрээс нь тэр магадлан итгэмжлэл хийж байгаа хүмүүс чинь нэг аргачлалаар бодоод, Нийцлийн аудит хийж байгаа хүмүүс чинь бас нэг өөр аргачлалаар бодоод зөрүү гараад байгаа гэж ойлгогдохоор хариулт өгөөд байх юм. Уучлаарай. Тийм зүйл байхгүй гэж харж байгаа. Яг л нэг зарчмаар явж байгаа. Тэгэхээр энд асуудал байна гэсэн үг байхгүй юу. Энийг бол цаашидаа ахин судалж бүр нэг талд нь гаргахгүй бол энэ байдлаараа улсын төсөв тэгээд л гарын салаагаар урсаад л дуусна нөхөд өө. Яг нэг хэдхэн хэсэгхэн хүмүүсийн мафийн гар хөлөөр ороод дуусна шүү. Тэр манай 3 дугаар сургуультай холбоотой асуудал. Нөхөд өө, энэ ондоо гүйцэтгэлийн санхүүжилтийг нь өгье гэсэн яам дээрээ очоод гацчихдаг юм байна лээ. Баахан яриа хэл болсоор байгаад 10 сар болчихож байгаа юм. Мөнгийг нь өгнө, өгөхгүй, өгнө, өгөхгүй гэж явсаар байгаад. Үгүй ээ, яаж тэр компани чинь ажил хийх юм бэ. Би хүүхдийн эрхийн асуудал ярьж байгаа байхгүй юу. Энэ хүүхдүүд 3, 4 жил тэгээд хүйтэн байранд өвлөчих юм уу нөхөд өө гэж. Энэ дээр нэг.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ганболд гишүүн асуултаа асууя.

Г.Ганболд: Зам, тээврийн хөгжлийн яамнаас Авто замын сангийн хөрөнгө 61 тэрбум гээд өнгөрсөн жилийнхтэйгээ адилхан байна. Өнгөрсөн жил бид нар төрөөс төрийн өмчит компаниудыг хувьчлах тогтоол баталсан. Энэ дотор АЗЗА-ын 34%-ийг хувьчилна гээд баталсан чинь гүйцэтгэхдээ эсрэгээр нь хувьчлалын ямар ч процесс явуулахгүйгээр буцаагаад бүр нэгтгээд АЗЗАН гээд нэгтгэл бий болгоод, 61 тэрбумыг чинь дахиад дээр

нь нөгөө төрөөс шинэ компани байгуулах уу гэсэн чинь нөгөө АЗЗА-ууд чинь дээрээ уг нь яам ингээд тэр 61-ээ хуваагаад өгдөг байсан бол дахиад давхар дээлтэй болсон. Хэн тэр АЗАН гэдэг байгууллагыг ямар тушаал шийдвэрээр байгуулаад ингээд яваад байгаа юм бэ. Өчигдөр ээ Авто замын байгууллагын үйлдвэрчний эвлэлийнхэн энийг эсэргүүцээд зогсож байлаа шүү дээ. Үнэн шүү дээ. Өмнө нь энэ чинь 2, 3-ыг байгуулаад, бүсчилж байгуулж үзэж дампуураад, бүр босоогоор нь дахиж байгуулж үзэж дампуураад болохоо байгаад больчихсон юмыг дахиж босгож ирээд байх юм. Энэ чинь ямар бодлого яваад байгаа юм бэ. Энэ дээр Халтар сайд нэг хариулт өгөөч.

Энэ боомтын зарим нэг юмнуудыг ойлгохгүй байна Жавхлан сайд аа, Яамгүй 3 сайд байгаа. Нөгөө 2 нь болохоор Хэрэг эрхлэхийн даргын багц дээр төсөв нь яваад байх шиг байх юм. Түгжрэлийн үндэсний хорооны даргын төсөв энэ тэр чинь бол Хэрэг эрхлэхийн даргын юман дээр явдаг юм байна лээ шүү дээ. Тэгэхээр энэ Боомтын сайд чинь тэгээд төсвийг нь шууд захирагч нь хэн юм. Төрийн нарийн байхгүй. Тэгээд төсөв ингэж баталж болох юм уу. Хэрэв батлах юм бол 3 сайд дээр нь адилхан ингэж төсөв задалж батлах ёстой. Эсвэл нөгөө 2-ыг нь ингээд Хэрэг эрхлэхийн багц дээр, Боомтын сайдыг ингээд тусад нь явуулж байгаа энэ өөрөө яагаад ч болохгүй л ийм хууль зөрчсөн л үйлдэл байх шиг байх юм.

Барилга, хот байгуулалтын яам дээр саяын Батлут гишүүний ярьж байгаа үнэн. Энэ бол дампуурсан шүү. Энэ дээр бол төр шалгалт хийж энийг нэг талд нь гаргахгүй бол ерөөсөө дур зоргын болсон. Тэнд ерөөсөө магадлан хийдэг Барилга хөгжлийн төвийн хэдэн нөхдүүд, тэгээд магадлан хийдэг хүмүүс нь ямар ч хариуцлага хүлээхгүй гаднын хөндлөнгийн хүмүүс байгаа байхгүй юу. Экспедицийн хүмүүс нь. Тийм учраас тэд нар чинь дараа нь хэн ч хариуцлага

хүлээхгүй. Бүр ингээд даблдаад, триплдээд 3, 4 дахин төсвийг нь нэмээд, энэ чинь төсвийн хуулиараа хэрэв төсөвт өртөг нэмэгдсэн бол 15% дээр нь шууд нэмэлт гэрээ хийх эрх байгаа шүү дээ. Нэг компани тэрбум төгрөгийн тендер аваад явж байсан бол экспертизээр ороод 2 тэрбум боллоо гэхэд 150 сая дээр нь л нэмэлт гэрээ хийж болно. Гэтэл тэгэхгүйгээр бүгд дээр нь ингээд хууль зөрчсөн, наадуул чинь бүгдээрээ шоронд орохоор юм явж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр Аудитын газар, Сангийн яам, Их Хурлаас ч гэсэн Байнгын хорооноос ажлын хэсэг гарч хамгийн өндөр үнэтэй магадлан хийгдсэн, ийм төсөвт өртөг нь олон дахин нэмэгдсэн зам, барилга, эрчим хүчний төслүүдийг бол шалгах ёстой шүү. Тэгээд ер нь дээр ингээд Сангийн яам ч гэсэн аудитын газар ч гэсэн зүгээр тэнд нэг хэдэн нөхдүүдийн экспертизээр ингээд л тэгээд 700, 800 сая байсан юмнуудыг 2.5, 2.6 тэрбум хүртэл болчихсон шахуу юмнууд байна лээ шүү дээ. Энэ чинь ер нь бол орон нутгийн баригдаж байгаа барилгуудын чинь 1м2 нь 3-5 сая болчихсон юм биш үү. Улаанбаатар хот бол ер нь нэлээн өндөр зэрэглэлийн орон сууц 1м2 нь 5 сая, 6 сая байх шиг байна. Гэтэл орон нутагт баригдаж байгаа жиижиг барилгуудын ер нь метр квадратыг нь тооцоод үзэх юм бол 3-5 саяар руу оччихсон юм байна лээ шүү дээ энэ барилгууд чинь. Тэгээд энэ дээр бас Сангийн яам ер нь авахдаа тэр экспертизийг давхар магадалдаг, Аудитын дүгнэлт гаргаж байж энэ санхүүжилтүүдийг өгөхгүй бол энэ нэлээн цаашидаа.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Зам, тээврийн яамны дэд сайд, дараа нь тэр Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга бас хариулаарай. Ажлын хэсгийн 4 номерын микрофоныг өгөөрэй.

Л.Халтар: Ганболд гишүүний асуултад хариулъя. Төрийн болон хувийн өмчтэй нийт 32 АЗЗА-ийн Монгол Улсын хэмжээнд байгаа зам арчилт, засвар

дээр арчлалт дээр 2024 онд 56 орчим тэрбум төгрөг тавигдаад, үүнээс 20 тэрбум төгрөгийг нь бол төлбөр авах цэгээрээ бид нар орлогоо олох ёстой. Энэ 32 АЗЗА-с 12 АЗЗА нь бол хувийн хэвшлийн, 20 нь төрийн өмчтэй компаниуд байгаа. Ингээд Засгийн газрын тогтоол гарсан 20 АЗЗА-г нэгтгэсэн 1 толгой компанитай болгоно гэдэг Засгийн газрын тогтоол Төрийн өмчийн бодлого зохицуулалтыг газраас ороод, ингээд тогтоол батлагдаад мөрдөх ажилдаа орж байна. Энэ 20 АЗЗА-г 1 толгой компани болгоод, ингэснийхээ дараа нөгөө Их Хурлаас баталсан 35%-ийг нь хөрөнгийн биржээр хувьчлах асуудал явагдана гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа юм. Ер нь бол зүгээр манай АЗЗА, АТҮТ, Зам тээврийн хөгжлийн төв гээд ийм хоёрдмол удирдлагатай байгууллагууд байдаг юм. Үйл ажиллагаа нь болохоор салбарынхаа яам дээр, нөгөө бусад төлөвлөгөө баталдаг барьдаг бүх юмнууд нь болохоор ТӨБЗГ дээр явдаг нэг ийм хоёрдмол удирдлага л яваад байгаа юм да. Уг нь энийг болдог бол яг тэр үйл ажиллагаа хариуцдаг газар нь өгөөд л, ингээд хариуцлага аль алийг нь яриад явбал цаашидаа бас хэрэгтэй болов уу л гэж ийм байдлаар товчхон хариулъя.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Ц.Баярбат: Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Баярбат. Ганболд гишүүний асуултад хариулъя. Барилгын тухай хуулийн дагуу зураг төслийн экспертүүдийн сонгон шалгаруулалтыг бол Барилга, хот байгуулалтын сайдын баталсан журмын дагуу Барилгын хөгжлийн төвөөс зохион байгуулж, сонгон шалгаруулж ажиллуулдаг. Түүнээс гадна экспертүүд бол яг өөрийн гаргасан дүгнэлтдээ хариуцлага хүлээнэ гэдгийг нь бол Барилгын тухай хуульд бүр заагаад тодорхой тусгачихсан байгаа. Тэгэхээр энэ гарч байгаа аливаа асуудалтай

холбоотой юм бол шууд эксперт өөрөө хариуцлага хүлээхээр хууль нь зохицуулалттай байгаа юм. Ер нь төсөвт өртөгт магадлал хийж байгаа асуудлуудыг бид нар цаашид бас олон улсынх нь жишигийн дагуу болгох ёстой гэж ингэж харж байгаа. Одоо энэ дээр гол асуудал үүсээд байгаа нь юу байна гэвэл Экспертийн шатад төсөвт магадлал хийдгээс болоод эргээд бүх асуудал төр хариуцах ийм хэлбэр лүүгээ орчхоод байгаа учраас бид цаашид гүйцэтгэгч өөрөө төсвөө зохиож орж ирж, энэ хугацаанд гарч байгаа эрсдэлүүдээ өөрсдөө үүрдэг энэ чиглэл рүү орж ажиллах ийм байдлаар бид нар ажлаа төлөвлөөд ингээд явж байна. Ер нь зүгээр тендерийн шатад өгсөн үнийн дагуу ажлуудыг гүйцэтгэдэг байх нь зүйтэй. Энэ дээр харин хяналтын төсвийг бол гаргадаг байхаар ийм өөрчлөлтийг оруулахаар бид нар бас ажиллаж байна.

Т.Энхтүвшин: Даваасүрэн сайд ирсэн байна. Даваасүрэн сайдын микрофоныг өгье.

Ц.Даваасүрэн: Тэр нэмэлт гэрээний асуудал тэр өөрөө салбар яамнууд нь хариуцдаг асуудал байгаа юм л даа. Манайх бол магадлан л хийж өгнө. Тэгээд уг нь бол 15 хувиас дээш байвал тэгээд салбар яамдууд нь хуулийнхаа дагуу илүү гарсан тэр дүнгээс магадлангийн зардлаас илүү дүнд бол уг нь тендер зарлах ёстой, тэрийг нь салбарын яамдууд хариулна биз. Энэ магадлан хийж байгаа асуудал дээр бол анхаарах хэрэгтэй. Монгол жсоохон. Бүгдээрээ нэг сургуулийн, нэг үеийн найз нөхөд, нэг салбарт ажиллаж байсан гээд. Би Сангийн яаманд ажиллаж байх үеэс ч мэднэ. Энд бол ерөөсөө маш том хуйвалдаан явж байдаг. Өнөөдрийг хүртэл явж байгаа юм. Тэгэхээр энийг яаж өөрчлөх юм бэ гэдэг дээр. Энэ чинь ингээд нөгөө нэг хөндлөнгийн экспертизээс авч байж магадлан хийлгэж хэж байгаа шүү дээ. Тэгээд Монгол жсоохон юм чинь ингээд

хоорондоо танил, тэгээд хуулиараа яг хатуу хариуцлага хүлээх ийм тодорхой заалт байна уу гэвэл бас байхгүй. Тийм учраас бол цаашидаа барилгын хуульд бол бид нар магадлан итгэмжлэл хийж байгаа экспертүүдийн асуудал, мөн энэ зураг төсөв хийж байгаа экспертүүдийн асуудал энэ тэр дээр бол бүүр нэлээн чангатгасан заалт хийж өгье гэж ингэж бодоод байгаа юм. Бусад улс орнууд бол Төрийн бус байгууллагаараа дамжуулаад бас ингээд л хийдэг л юм байна лээ л дээ. Яалт ч байхгүй л эксперт магадлан бол хаана ч бол байгаад байгаа юм. Тэгэхдээ энийгээ яаж хийх вэ гэдэг асуудал. Гадаад оронд бол ингээд манайх шиг барилгын сургуулийн төсөв бол тэгээд ингээд батлаад өгчихдөггүй л байгаа байхгүй юу даа. Манайх бол ингээд яг хуучин загвартай, дураараа нэг Төсөвчин гэдэг хүн сургуулийнх бол тэд, эмнэлгийнх бол тэд гээд ингээд батлаад өгчхөж байгаа байхгүй юу. Тэгээд тэр нь хууль болоод хэрэгжээд явчхаж байгаа юм. Гадаад орнуудын туршлагыг хараад байхад яагаад байна вэ гэвэл зүгээр ингээд нэг баримжаа үнэ байгаа шүү дээ. Хяналтын төсөв гаргаад өгчхөж байгаа юм. Хяналтын төсөв гаргаад өгчхөж байгаа юм. Тэгээд тэр хяналтын төсөв дээрээ тендер зарлаад, тендерээр тэр үнийг тогтоогоод байгаа байхгүй юу. Тэр сургуулийн төсөвт өртөг хэд юм бэ гэдгийг гадаад орнууд, хөгжингүй орнуудад бол. Манайд бол үгүй нэг төсөв чинь ингээд батлаад, баталгаажуулаад, магадлангаар оруулаад, ингээд 2, 3 шатны бүр хууль болгоод хаячхаж байна. Тэгээд Их Хуралд орж ирээд, нөгөөдөх нь хууль болчхож байна шүү дээ. Тэгэхээр энэ тогтолцоогоо бид нар өөрчилж явахгүй бол энэ их төвөгтэй. Тэгээд хувийн байх уу эксперт, төрийн болгох уу гэдэг өөрөө бас нэг асуудал шүү. Ингээд хувийн хүнээр авчраад ингээд эксперт хийлгээд, магадлан гаргаад байх юм уу гэрээгээр, төрийн болгочихлоо гээд сайжрах уу, төрийн болохоор илүү л авлигад өртдөг гэж ингэж ярьдаг. Тэгэхээр энд бол тогтолцооны нэг ийм асуудал бий. Тэгэхдээ цэвэр хүний ёс зүй,

ёс суртахуунтай холбогдолтой асуудал шүү энэ бол. Хэдийгээр хууль байлаа ч гэсэн л тэгээд л ёс зүй муутай байх юм бол тэр далд хулгай чинь байгаад л байна гэсэн үг шүү дээ. Тэгээд энийг яаж шийдэх юм бэ гэдэг бол Барилгын хуулийн шинэчлэлийн хүрээнд Их Хурал нэлээн сайн нарийвчилж ярьж ингэж шийдэх ёстой асуудал бол бас энэ мөн шүү. Тэгэхгүй бол төсөв дагасан төсөв дээр ижилхэн шахуу сургуулиудын төсвүүд хоорондоо эрс өөр ийм юм байсаар л байгаа шүү дээ. Жишээлбэл, би нэг тодорхой жишээ хэлэхэд бодит амьдрал дээр болсон явдал шүү. Намайг Боловсролын яаманд байхад гэж санагдаж байна. Ингээд хоорондоо ярьчихаж байгаа байхгүй юу. Энэний төсөв ашигтай төсөв шүү. Чи ороорой гэж хоорондоо ярьж байна гэж байгаа юм. Тэгээд нөгөөдхийг нь гаргахгүй болохоор нөгөө тендерийн хороо нь хямд өгснийг нь гаргахгүй, тэгээд л нөгөөдөх нь шүүхээр явсаар явсаар байгаад нөгөө төсөл нь хэрэгжихгүй болж байх жишээтэй. Энэ бол олон жил үргэлжилж байгаа, тэгэхдээ шийдэгдэхгүй яваад байгаа л нэг ийм асуудал байгаа юм. Тэгэхээр энийг тогтолцооных нь хувьд, хууль, эрх зүйн хувьд нь Их Хурал эрс өөрчлөлт шинэчлэлт хийх хэрэгтэй. Төсвийг нь ер нь яаж гаргаж ирж байх юм.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 2 дугаар микрофон. Занданбат дарга.

Д.Занданбат: Төсөвт өртөг дээр Улсын Их Хурлын 2022 оны 72 дугаар тогтоолын дагуу аудитын байгууллага төсөвт өртөг дээр аудит хийж байгаа. Сэдэвчилсэн. Тэгээд 11 сард багтааж Улсын Их Хуралд хүргүүлэх ёстой. Сая Даваасүрэн сайд бол их тодорхой ярьчихаж байна. Аудитын явцад хөгжлийн төвүүдээс ирж байгаа магадлал дээр ингээд хяналт хийгээд явж байхад бол үнэхээр бас эрх зүйн орчны зохицуулалт, нарийвчилсан зохицуулалт хэрэгтэй, шаардлагатай байдаг асуудал бол их хэрэгтэй юм байна лээ. Бид нар

аудитынхаа дүгнэлтэд ч гэсэн дотоод хяналтаа 1 дүгээрт сайжруулаач, субъектив сөрөг нөлөөллийг бууруулах эрх зүйн нарийвчилсан зохицуулалт хэрэгтэй, шаардлагатай байна гэдэг маягаар бол дүгнэлт хийгээд явж байгаа. 11 сард өгөх тэр аудитын дүгнэлтээр бол энэ их тодорхой гарна. Сая хэлж байна шүү дээ. Хөгжлийн төвүүд дээр хийж байсан магадлал дээр аудит тэрийг нь дахин хянаж үзээд төсвөөс одоогийн байдлаар 283 төсөл арга хэмжээ дээр хийгдчихсэнээс 78 тэрбум төгрөгөөр бууруулаад явж байна гэж. Тэгэхээрээ түрүүн бас Батлут гишүүн хэлж байна лээ. Энэ хэмжээгээр төсвийн өртгийг нэмэгдүүлэх боломжийг хийж байна. Үүний цаана ажлын хариуцлага байгаа гээд. Төрийн албан хаагч гэдэг юм уу магадлал хийж байгаа хүмүүсийн ёс зүй, сахилга хариуцлагыг өндөрсгөж сайжруулах шаардлага бол үнэхээр харагдаж байгаа.

Т.Энхтүвшин: Хариулт болсон уу. Жавхлан сайд. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Ганболд гишүүний асуултад хариулъя. Ийм шүү, яамгүй асуудал эрхэлсэн сайд нарын төсөв яг ингэж л явдаг, бүгдээрээ ижилхэн явдаг. Ерөнхий сайдынх ч бас ингэж явна. Шадар сайдынх ч ингэж явна. Ажлын албууд нь бүгд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр байдаг юм. Тэнд төсөв нь явдаг байхгүй юу. Үгүй ээ, наадах чинь Хилийн боомтын захиргаа гээд энэ чинь захиргааны төсөв байхгүй юу. Наадах чинь өөр. Сайд нь бол өөрөө төсвийн эргэлтэд захирагч нь. Тэр боомтын захиргааных нь дарга нь бол төсвийн шууд захирагч нь. Жишээ нь манай Амарсайхан Шадар сайдынх бол бас л адилхан тэгж явдаг. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр яг ажлын албаных нь төсөв нь байж байна. Харьяа байгууллагуудынх нь тус тусдаа төсөвтэй, харьяа байгууллагуудынх нь дарга нар нь төсвийн ерөнхийлөн захирагч гээд. Энэ захиргаа нь тусдаа

шүү. Тулга сайд тэрийгээ тайлбарлаад өгчих.

Т.Энхтүвшин: Тулга сайд гүйцээгээд хариулчих. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Б.Тулга: Ганболд гишүүний асуултад хариулъя. Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга Тулга байна. Манайх төсөв бол 2 бүрэлдэхүүнд байгаа. Яг Үндэсний хорооны ажлын албаны төсөл нь бол Хэрэг эрхлэхийн төсөв дотор нөгөө хоёртойгоо адилхан суусан байгаа.

Т.Энхтүвшин: Ганболд гишүүн тодруулъя. Ганболд гишүүний микрофоныг өгөөрэй.

Г.Ганболд: Их Хурлаас ингээд хууль гаргаад, тэр АЗЗА-уудын асуудал дээр яагаад яам, Засгийн газар бүр эсрэгээр нь ийм юм гаргаад байгааг би ойлгохгүй байна л даа. Тийм учраас бас би авто замын салбарыг ойлгодог хүний хувьд Ерөнхий сайдад асуулга тавья л гэж бодож байна. Өөр хариулт авахгүй юм шиг байна. Халтар сайд аа. Тэгээд Даваасүрэн сайд тэгээд л углуургаар нь л мэддэг юм байна шүү дээ. Та олон жилийн өмнөөс л мэддэг юм байна. Ийм мафи явж байгааг, ийм сүлжээ хийдгийг бүх л салбар дээр байдгийг та мэддэг юм байна шүү дээ. Тэгээд таныг мэддэг учраас л энийг залруулаад ир гээд сайдаар томилсон юм шүү дээ. Одоо тэгээд та тэр хуулиа оруулж ирээд Их Хурлаа цэгцэл л дээ. Ингээд завхраад яваад байх юм бол энэ чинь цаашаа замаа алдлаа шүү дээ. Тэгэхээр та юмыг нь мэддэг, тэртээ тэргүйг дотор нь бантан байдгийг нь бүгдийг нь л мэддэг юм чинь одоо ингээд хуулиа өргөн бариад энийг энэ жилийн төсвөөс эхлээд цэгцэлмээр байна шүү дээ. Тэгэхгүй бол энэ чинь болохгүй. Энэ чинь арай дэндэж байна. Би ямар ч гэсэн Их Хурлын гишүүний хувьд нэмэгдсэн төсвүүд дээр бол анхаарал татсан хэд дээр нь заавал би.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Даваасүрэн сайд

Ц.Даваасүрэн: Би ажил аваад 7, 8 сар болж байгаа юм. Тийм учраас бол надад тэгж хууль оруулж ирээд батлуулах хугацаа бол байх байсангүй. Ер нь бол ажлын хэсэг гаргаад ажиллаж байна. Гадаад улс орнууд руу явуулж бас туршилага судлуулж байна. Ер нь яаж төсвийг тодорхойлж байгаа юм, төсвийг яаж гаргаж байгаа юм, төсөвт өртгийг тодорхойлох чиглэлээр бол ер нь би бол зарчмын бүр агуулгын өөрчлөлт, шинэчлэлт хийх ёстой л гэж ингэж хараад байгаа. Би түрүүн та бүгдэд бол концепцоо хэллээ. Төсвийг яаж тодорхойлж байх юм, төсөвт өртгийг яаж гаргаж байх юм гэж. Одоо бол зүгээр хуулийн төслийн ажлын хэсэг бол ажиллаад явж байна. Би намрын чуулганд бол өргөн барина. Тэр үед бол харин ёстой сайн ярьцаах хэрэгтэй. Тэгэхдээ энд бол нэлээн том өөрчлөлт яригдах гээд байгаа учраас бол Барилгын хууль дээр учир дутагдалтай юмнууд нэлээн их.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ганбаатар гишүүн асуулт асууя.

С.Ганбаатар: Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд төсөв батлах гэж байгаа. Тэгээд яам холбогдох газрууд нь бол онцгой үүрэгтэй. Төсвөө тайлбарлаж, ойлгуулж, батлуулах үүрэгтэй. Ардын намын эрх баригчид их биеэ тоожээ. Үгүй ээ, мөн их биеэ тоожээ. Та нар дээр ард түмэн бөгсөнд нь хүйтэн жин тавина даа. Ер нь тэгээд л Жавхлан сайд, Тулга сайд, Даваасүрэн сайд 3 л байна. Бусад нь хаачсан юм. Тэр нөгөө янз бүрийн тэр хөгжлийн төвүүдийнх нь дарга нар нь хаачсан юм. Энэ төсвөөс чинь цөм цөм иддэг, бүр хагартлаа баяждаг бүхэл бүтэн арми бий болчихлоо шүү дээ. Дараа нь гишүүдэд, тэр намуудад нь тэр сонгуульд нь хандив өгдөг юм гэнэ лээ. Энэ тэнгэлийг зогсоох гэж л өнөөдөр бид төсвөө батлах гээд ярилцаж байгаа

ухаантай шүү дээ. Тэгээд энэ дээр 2 зүйл ярья.

Аудит Улсын Их Хурлын нүд чих болсон аудит бол ажлаа хийсэн шүү. Энэ дээр та нар ингээд харах юм бол нийт төсвийн 358 барилга байгууламжийн ангилалд байна. 497 төсөл, арга хэмжээнээс. Тэрний 21 төсөл нь магадлалаар баталгаажих шатдаа, тэгэхэд ороод ирчихсэн. 43% буюу 153 төсөл, арга хэмжээ иж бүрэн бус, холболтын зураг төсөл нь хийгдээгүй, юу ч байхгүй. Энэ бол цөм иднэ гэсэн үг. Энэ чинь ороод ирчихсэн. Энэ дээр яах вэ, боловсролын, эрүүл мэнд, холбогдох бусад яамдууд руугаа орчхож байгаа юм. Энэ бол цаад утгаараа хүүхдүүдээс, тэр эмнэлэгт хэвтэж байгаа өвчтэй хүнээс, ажилгүй залуучуудаас дээрэм хийж байгаа явдал шүү дээ. Ямар төсвийн хулгай. Энэ дээр ороод ирчихсэн. Барилга, байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх гээд хуульдаа заачихсан. Энэ дээр нийцээгүй 83% нь байна гэж байгаа юм. Үгүй ээ, энэ мөн агуу шүү. Магадлалтай зураг төсөлтэй төсөл арга хэмжээ хэрэгжүүлснээс бус ингээд идэж ууж байна. Цөм шааж байна та нар гэдэг юм гарчихсан байна. Тэгэхлээр аудит 2 тогтоол явуулсан байгаа юм шүү. 2 албан шаардлага. Зөрчил арилгуулах тухай гээд. 2023 оны 10 сарын 13-нд 2 шаардлага 1 өдөр явуулсан байна. Занданбат даргаас. Хэрэгжүүлээгүй, байхгүй. Эи энийг дэлгэрэнгүй уншиж хайран цаг үрээд яах вэ. Тэгвэл Улсын Их Хурал энэ төсвийг батлах юм бол бид хууль зөрчинө гэсэн үг шүү. Бидний ард түмний нүд бол чих болсон Улсын Их Хурлаас Аудит нь ингээд дүгнэлт гарчхаад байхад, том тэнгэл болно гэж ойлгож байна. Энийг би Их Хурлын чуулган дээр бас ярина гэж ойлгож байна. Ингээд энэ дүгнэлт хэзээ хэрэгжих вэ. Надад хариулах сайд байгаа юу. Энэ зөрчил арилгуулах тухай гэдэг 2 албан шаардлага шүү. Энэ дээр бүүр ингээд экспертизүүдэд, албан

тушаалтнуудад хариуцлага тооц гэсэн шаардлага өгсөн байна. Байхгүй.

2 дугаар асуулт. Бүх талаараа хүчтэй байх гэж оролдоно гэдэг бүх талаараа сулын шинжтэй. Ер нь бол яамдуудын юм орж ирж байна. Зам, тээврийн яам 682 тэрбум төгрөгөөр зарлага, амьдрах юм байна л даа. Барилгын яам 418 тэрбум төгрөгөөр зарлага гаргах юм байна. Ингээд хөрөнгө оруулалт, зардал гаргана. Тэгэхлээр Хүнс, хөдөө аж ахуйн яам гээд 568 зарлага.

Т.Энхтүвшин: Хэн хариулах вэ. Дүгнэлттэй холбоотой асуудал асуугаад байна шүү дээ. Дүгнэлт, албан шаардлагын биелэлт хэзээ хэрэгжиж эхлэх вэ гээд. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Манай чиглэл чиглэлийн сайд нар маань уг нь төсвөө өөрсдөө сайхан хамгаалчихдаг л, ярьчихдаг л болмоор байгаа юм даа. Саяын Ганбаатар гишүүний хэлж байгаа тоонууд бол энэ чинь аягүй том салбарын яамнууд шүү. Зөвхөн яг аппаратын зардал бол биш. Наадах чинь хөрөнгө оруулалт. Жишээ нь Хөдөө аж ахуйн яам наад 500 хэдэн тэрбумын чинь жишээ нь 230 тэрбум нь цэвэр тэр хүнсний сэргэлт, хүнсний аюулгүй байдалтай холбоотой хөнгөлөлттэй зээл, хөтөлбөр гээд дандаа тийм санхүүжилтүүд ч байгаа. Тэр нь урсгал зардал, хөрөнгө оруулалтууд ч байгаа. Аппаратынх нь бол жижигхэн шүү дээ зардал нь. Тийм учраас салбарын яамдууд жишээ нь Хөдөө аж ахуйн яам бол маш сайхан сайхан хөтөлбөрүүд байгаа шүү дээ. Тэрийгээ сайхан дурдчихмаар байгаа байхгүй юу.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон Халтар сайд.

Л.Халтар: Ганбаатар гишүүний асуултад зүгээр товчхон хариулчихъя. Энд 682 тэрбум төгрөгөөс 16,7 тэрбум төгрөг нь л манай яамны урсгал засвар

байгаа юм. Бусад нь бүгдээрээ хөрөнгө оруулалтын асуудал. Өөрөөр хэлбэл энд тавигдсан бүх замын их засвар, тэгээд шинээр зам барих болон шилжих хөрөнгө оруулалтууд нь үлдсэн нь байгаа юм шүү. Бараг 660 орчим тэрбум нь бол дандаа хөрөнгө оруулалтад явж байгаа. Яамны урсгал зардал бол ердөө л 16,1 тэрбум төгрөг.

Т.Энхтүвшин: Даваасүрэн сайдын микрофоныг өгье.

Ц.Даваасүрэн: Тэр яамны төсөв 413 чинь бол хөрөнгө оруулалт орсон нийт төсөв шүү. Аппаратын зардал буюу яамны төсөв нь өөрөө ер нь 10 тэрбум л юм. 403 тэрбум нь бол хөрөнгө оруулалтын зардал байгаа. Манайх 10 юм байна лээ.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 2 дугаар микрофон. Хэн хариулах юм. 2 албан шаардлага өгсөн гээд байна шүү дээ. Аудитын газар Занданбат дарга. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон. Танайхаас өгсөн 2 албан шаардлагын биелэлт биелсэн үү гээд асуугаад байна.

Д.Занданбат: Ганбаатар гишүүн ээ, манай сая төсвийн төсөлд аудит хийж байхад гаргасан шаардлага. 11 сарын 15-ны дотор биелэлтийг Үндэсний Аудитын газарт ирүүлэхээр ингээд 2 дахь заалт болгоод ингээд бичсэн байгаа. Хугацаа нь бол арай болоогүй 11 сарын 15.

Т.Энхтүвшин: Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

С.Ганбаатар: Үгүй ээ, энэ чинь ийм тоглоомтой юм байх уу. Төсөв батлахаасаа өмнө төсөвтэй холбоотой шаардлагыг ингэж биелүүллээ. Энийг нь үнэхээр би барсан гүйгээдэг хариугаа өгөх ёстой болохоос биш батлагдсаны дараа ямар тоглоом биш энэ хүн рүү юу явуулдаг юм бэ. Тэгээд яах вэ, сайд нар хариулж байна л даа. Би хуулийн хэллэгээр нь л хэлж байгаа юм. Нийт

зарлага тэгээд тэр олон хөрөнгө оруулалтуудыг л ийш тийш нь тараах гэж л амьдарч байгаа хүмүүс шүү дээ та нар. Тэр цалин авч байгаа хүмүүс. Тэр утгаар нь би хэллээ. Тэгээд Зам, тээврийн яамнаас нэг асуучихъя даа. Юу гэвэл бүх талаараа хүчтэй байх гэж оролдоод л бүх талаараа сул болчихлоо. Метро тойруу зам барих уу. Энэ дээрээ хүчтэй төвлөрч чадах нь уу. Энэ Улаанбаатарын асуудал гэж битгий хаяарай. Монголын асуудал болчихсон. Энэ дээрээ бүх төсөл хөтөлбөр, зээл, төсвөө зарцуулаад энэ дээр үр дүн гарах уу. Энэ жил хэдийг.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 4. Халтар сайд.

Л.Халтар: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Та намайг бас л нийслэл рүү чихлээ гэх байх. Яах аргагүй л нийслэлийн асуудал. Нийслэл өөрөө тусдаа төсөвтэй. Метро энэ бүх асуудлууд бол нийслэл дээр явж байгаа. Тойрог замын хувьд бол концесс зарлагдаад явж байгаа шүү дээ. 2 гүүртэйгээ. Төсөв дээр юм ороогүй. Концесс бол нөгөө ТЭЗҮ боловсруулах, зураг төсвөө хийх, барих, ашиглах гэсэн нөхцөлтэй явж байгаа юм. Жагсаалтад бол байна. Энэ чинь нийслэлийн өөрийнх нь том багц дээр явж байгаа.

Т.Энхтүвшин: Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Ганц 2 асуулт байна. Тэгээд ерөнхийдөө асуулт хариулт болоод л дуусах юм даа. Сая Ганболд гишүүн асуулаа. Замын сангийн 61 тэрбум төгрөг тавьсан. Ноднин жил яг 61-ээрээ байж байгаа. Тавьсан байсан. Тэгээд энэ жил яг тэр чигээрээ л ерөөсөө хуулаад тавьчихаж л дээ. Тэгээд энийгээ ихэсгэж болдоггүй юм уу. Одоо бид чинь хамгийн том амжилт бол ерөөсөө бүх аймгаа Улаанбаатар хоттойгоо холбочихсон гээд л онгироод байгаа шүү дээ. Одоо нөгөө зам чинь буцаад эхнээсээ эвдэрч эхэлж байгаа байхгүй юу даа. Хамгийн гол асуудал бол зам арчилт шүү

дээ. Энийгээ бол бүгд мэдэж байгаа. Тэгэхээр жил, жил нэмэгдүүлээд явж байсан хөрөнгөө энэ жил яагаад нэмэгдүүлээгүй юм бэ. Энэ дээр яагаад ядаж 80, 90 лүү очиж тавьчихаагүй юм бэ. Ер нь бол замын сан чинь юунаас бүрддэг билээ. Энэ чинь онцгой татвараас орж ирж байгаа. Онцгой татвараас гэхэд энэ жил бол 300-аад тэрбум төгрөг орох ийм бололцоотой гэж харагдаж байгаа шүү дээ. Дээрээс нь авто зам ашигласны төлбөр. Бид нар нөгөө авто замууд дээр байж байгаа төлбөр хураах цэгүүд. Эндээс 25 тэрбум төгрөг орно гэсэн тооцоо байх шиг байна. Тэгээд авто бензин, дизелийн түшинээс 17 тэрбум төгрөг онцгой татвараас орох юм шиг байна. Тэгээд энийг яагаад 10 тэрбум, 20 тэрбумаар нэмээд ядаж жсоохон өсгөөд явчаж болдоггүй юм бэ. Түрүүн тэр Ганболд гишүүний хэлээд байгаа нэг асуудал байгаа шүү дээ. Нэг том толгойтой болгочихсон. Бүх АЗЗА-уудаа нэг том толгойтой болгочихсон. Одоо тэр том толгой дээр чинь 61 тэрбум төгрөгөөс чинь хэдийг нь аваад үлдчих юм. Тэгээд хэд нь яг жинхэнэ замынхаа арчлалт дээр нь очих юм. Ер нь бол 3 нүхний 1 нүхийг нь л бөглөөд яваад байгаатай адилхан байгаа байхгүй юу даа. Тэгээд болдог бол энэ дээр Сангийн сайд хариулмаар байх юм. Яг төсөв барьж байгаагийн хувьд. Наад хэдэн хүмүүс чинь худлаа л яриад байна шүү дээ. Зовлонгоо л яриад байна шүү дээ. Тэгээд зовлонг нь бид энд шийдэх ёстой л байхгүй юу даа. Түүнээс биш мэдэхгүйдээ ч энийг асуугаад байгаа юм биш шүү дээ. Яагаад шийдээгүй байгаа юм бэ. Яагаад нэмээгүй байгаа юм бэ гэдэг асуудлыг л яриад байна шүү дээ. Эсвэл замаа засах шаардлагагүй юм уу. Тэгвэл болж байна. Тийм хариулт авбал.

2 дугаарт Хөдөө аж ахуйн яам 71 тэрбум төгрөг Мал эмнэлгийн ерөнхий газар дээр тавьсан. Бид Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хороо дээрээс ноднин хавар энэ малын өвчинтэй бүр бүтэн 100% тэмцье. Тэгж байж бид нар

малынхаа түүхий эд, мал, махыг бүгдийг нь үнэд оруулах, экспортод гаргах ийм боломж бололцоо нээгдэнэ шүү дээ. Одоо бол гарахгүй. Гарахгүй ч байгаа. Тэгээд талаар нэг хаягдаад тэр ноос нэхий чинь бүгд талаар нэг хаягдаад гуу жалгаар хаягдаад явж байгаа шүү дээ. Өвчтэй малын махыг хэн авах юм. Өвчтэй малын түүхий эдийг хэн авах юм. Энэ чинь бүх юмны ганц гогцоо нь ерөөсөө малынхаа өвчин дээрээс л тогтчихоод байгаа шүү дээ. Тэгээд бид нар Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дээрээс бүх мэдрэмтгий малдаа жилдээ 2 удаа вакцинжуулъя, энд 75-80 тэрбум төгрөг хэрэгцээтэй гэгчихсэн ийм тоо тооцоолол гараад, бид нар тогтоол гаргаж өгсөн. Тогтоол гаргаж өгсөн. Одоо энэ 71 тэрбум төгрөг чинь эндээ яг хүрэлцэх үү. Хөдөө аж ахуйн яам бүр тодорхой хариулж өгөөрэй надад. Хүрэлцэхгүй бол яагаад тэр бид нарын тогтоол ер нь хэрэгжихгүй хоосон тогтоол гаргаад ингээд байх шаардлага байгаа юм уу. Эсвэл малынхаа өвчинтэй тэмцэх шаардлагагүй байна уу. Бууж өгөх юм уу. Ийм асуудал байна.

3 дугаарт, Булган Хишиг-Өндөр чиглэлийн тойрогтой холбоотой асуудал. 31 км зам байгаа. Энэ дээр магадлан хийгдээд энэ хавраас эхлээд л магадлан ярьсан. Одоо яг магадлантай холбоотой асуудлууд сөхөгдөөд л явж байна. Хийгдээд л байдаг, хийгдээд л байдаг, тэр ч захирал нь ч байхгүй, энэ захирал нь ч байхгүй гээд л ярьсаар ярьсаар, явсаар байгаад л асуудал нь хоцорчихсон. Аль 2012 оны зурагтай л зам яваад байгаа шүү дээ. Энэ тендерт орохдоо бол 4, 5 тендер нь явагдаж байж арай гэж нэг эзэн.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Жавхлан сайд.

Б.Жавхлан: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Ийм учиртай байгаа шүү Бат-Эрдэнэ гишүүн ээ. Авто замын тухай хуулиар 5 янзын засвар байдаг. Арчлалт, урсгал засвар, ээлжит засвар, их засвар, гэнэтийн хүчин зүйл гээд. Энэ хуулиар

бол авто замын нэгдсэн сангаас зөвхөн арчлалт, урсгал засварыг л хийдэг. Их засвар болон бусад тэр гэнэтийн юм болон ээлжит засваруудыг тусдаа улсын төсвөөр зардал гаргаад ингээд явдаг юм байгаа юм. Тэгэхээр ирэх жилийн засварууд бол эндээс тусдаа байгаа. Тухайлбал Дэлхийн банкны 100 сая долларын зээлийг зөвхөн их засварт бид нар зориулна. Нөгөө Дорнодын тамын 50 гээд байдаг. Бусад 10 том ийм замын засварын бүр тулчихсан ажлууд байгаа. Энийг бүтнээр нь тийш нь зориулна. Анх удаа төсвөөс 350 тэрбум төгрөг зөвхөн замын их засварт зориулах гэж байгаа ийм томоохон бүтээн байгуулалтын жил болно ирх жил. Бид нөгөө мянганы зам гээд л их л олон янз янзаар хэлүүлж байсан даа. Энэ төсөл маань амжилттай 20 жил хэрэгжээд дууслаа. Өнгөрсөн жил Завхан аймгийн Загасан даваагаар сүүлийн холболтоо хийгээд бид 7000 км улсын чанартай ийм авто замтай болсон. Эргээд эд нар маань маш их их засвар шаардаж, энэ хугацаа нь болж ирж байгаа юм. Ингээд ирэхээр Зам, тээврийн хөгжлийн яамнаас гаргасан тооцооллоор жилдээ бараг доор хаяж 500 тэрбум шүү. 500-аас 1 их наяд төгрөгийн засвар шаардаж эхэлж байгаа ирэх жилүүдэд. Бид төсвөөс энийг дийлэхгүй болж ирж байна. Тэгэхээр энэ дээр бас нэг өөр бодлого явуулах, тэр АЗЗА-ууд дээр замуудыг арчлалтыг нь ч хариуцаад, тэр дээр нь тоолууртай болгох гэх мэт олон улсын сайн практик руу бид явахаас аргагүй болж ирж байгаа юм. Тийм учраас ирэх жилийн авто замын засвар бол хангалттай бөгөөд түүхэндээ байгаагүй хамгийн өндөр дүнтэй ийм төсөв бид оруулж ирсэн байгаа шүү.

Аймаг, нийслэл болгон өөрсдөө авто замын сантай. Дотоод тэр жижиг орон нутгийн шинжтэй замуудынхаа засваруудыг бол орон нутаг өөрсдөө тэр сангаасаа бол хийгээд явдаг байгаа.

Т.Энхтүвшин: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг өгөөрэй.

М.Ганхүлэг: Байнгын хорооны дарга, гишүүдэд өдрийн мэндийг хүргэе. Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Энэ жилийн хувьд бол мал эмнэлгийн зардал дээр 13,1 тэрбум төгрөгийг бас нэмэгдүүлэхээр оруулсан байгаа. Үүн дээр бол вакцинжуулалтыг нэмэгдүүлэх болон мал эмнэлгийн үйлчилгээний анхан шат дээрх тарилгыг үйлчилгээний хөлсийг нэмэгдүүлэх байдлаар бол нэмэлтээр орж ирж байгаа юм. Бид бүхэн 4 төрлийн вакцин дээр шүлхий, бог малын мялзан, үхрийн арьс товруутах, хонины цэцэг гэсэн 4 төрлийн вакцин дээр 52,5 сая тун вакциныг давхардсан тоогоор 54,7 сая толгой малдаа тарихаар бол тооцсон байгаа. Шүлхий өвчний хувьд бол бид бүхэн дэлхийн мал эмнэлгийн эрүүл мэндийн байгууллагын заавар зөвлөгөөний дагуу үхрээ бол жилд 2 удаа шүлхийн вакцин бол хамруулж байгаа. Энэ 13,1 тэрбум төгрөгийн нэмэгдлээр бол үхэр сүргээ бол бүрэн хамруулах бол боломжтой байгаа. Таны яг саяын хэлж байгаатай холбогдолтойгоор бол цаашид мал эмнэлгийн үйлчилгээний бог малын тодорхой бас нэр төрлүүд дээр бас нэмэгдүүлэх шаардлагатай. Ингэж байж бас бид бүхэн бүрэн Монгол Улсын хэмжээний эрүүл бүс болох боломжууд нь бүрдэнэ. Сая бас ОХУ-ын Мал эмнэлгийн газрынхантай уулзсан уулзалтаар нэлээдгүй асуудлуудыг, зөвлөгөөнүүдийг авсан. Өнгөрсөн жилийн хугацаанд ОХУ бол мал эмнэлгийн эрүүл бүс гэдгээ бол зарла гэсэн байгаа. Ингэхдээ бол хэсэгчилж биш нийтээр нь арга хэмжээ авсан шүү. Энэ дээрээ та бүхэн анхаараарай гэдэг саналыг бол хэлж байсан. Тэгээд энэ жилийн хувьд бол бид бүхэн нийтээр нь бол хийх бол боломж бололцоо төсвийн хувьд бол ийм боломжгүй. Зөвхөн үхэр сүрэг дээрээ бол бүрэн вакцинжуулахаар бол оруулсан байгаа.

Т.Энхтүвшин: Зам, тээврийн хөгжлийн дэд сайд. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг өгөөрэй.

Л.Халтар: Магадлан хийгдээд, Зам, тээврийн хөгжлийн төвөөс 3 өдрийн өмнө ирсэн байна. Магадлал хийгдсэн байна. 3 өдрийн өмнө Зам, тээврийн хөгжлийн төвөөс иржээ.

Т.Энхтүвшин: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Тэр Булган Хишиг-Өндөрийн магадлан ирчихсэн байна гэж байна. Тэгээд тэр чинь орох бололцоотой юу л гэж би асуугаад байгаа байхгүй юу.

2 дугаарт Жавхлан сайд надад зам заагаад яах вэ дээ. Наад зам арчлалтыг ярьж байгаа шүү дээ. Зам арчлалтыг ярьж байгаа байхгүй юу даа. Түүнээс биш та нар тэр их засвар дээр тавьсан хэдэн төгрөгөөрөө энийг хааж болохгүй байхгүй юу. Таны ирэх онд тавьсан түүхэнд байгаагүй их зам тавилаа, засвар хийх гээд байна гэж байна. Сайн байна. Гэхдээ 61 тэрбум төгрөг чинь засвар арчлал байхгүй юу даа.зүц Энэ засвар арчлал чинь энд хүрэхгүй байхгүй юу. Тэгэхээр энийгээ яагаад нэмээгүй юм бэ л гэж асуугаад байна шүү дээ. Тэгэхээр тэр их засварынхаа мөнгөөр хаачаад байж болохгүй байхгүй юу наадах чинь.

2 дугаарт сая Хөдөө аж ахуйнхан хэллээ шүү. Өөр мөнгө хэрэгтэй гэж тийм байх аа.

Т.Энхтүвшин: Жавхлан сайд. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон Халтар сайд гүйцээгээд хариулчих.

Л.Халтар: Жавхлан сайдын хэлсэн дээр нэмээд хариулчихъя. Саяын Жавхлан сайдын хэлдэг 100 сая долларын хүрээнд бид нар 2024 онд 20 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх гэж байгаа юм. Эндээс нийтдээ 7 зам дээр их засварын ажил, нийтдээ 249 км зам дээр их засвар,

3 газар буюу 125км дээр урсгал засвар, 8 гүүрийн засварын ажил, 51км зам 2 хэсэг газар дээр шинээр зам барих гээд нийтдээ 20 арга хэмжээ. Урсгал засварын хувьд бол зам арчлалт, урсгал засварын хувьд бол яг үнэндээ 50 хэдэн тэрбум төгрөг бол хүрдэггүй юм. 2024 онд бол бид нар 175 тэрбум төгрөгөөр саналаа явуулсан. Төсөвт орж ирж байгаа нь ингээд 56,4 тэрбумаар орж ирж байна. Цаашидаа бол ингээд зам бариад байдаг баригдаад.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя гэж байна. Халтар сайдын хэлдэг үнэн шүү дээ. Мөнгө чинь хүрэхгүй л байхгүй юу даа. Мэдэхгүй ээ, одоо 7, 8 жилийн өмнө шахуу 50 тэрбум төгрөгийн асуудлыг л бид нар ярьдаг байсан шүү дээ. Одоо дөнгөж 10 нэмэгдээд энэ чинь хэдэн жилийн дараа билээ 10 нэмэгдээд 61 тэрбум төгрөгтэй л байгаа байхгүй юу даа. Тэгээд тэр нүх, цоорхой, хагархай энээ тэрээ засах засварын асуудлыг л би яриад байгаа байхгүй юу. Энийг л ярьж байгаа юм. Тэр юун дээр нэг хариулт өгөөч. Саяынхаа тэр Булган Хишиг-Өндөрийн 31 дээр магадлал чинь ирчихсэн юм байна. Одоо орох боломж бололцоо байна уу, үгүй юу. Энэ чинь 2012 оны л зурагтай л зам яваад байгаа шүү дээ. Тендер нь зарлагдаад аж ахуйн нэгжүүд нь орохгүй. Юмны өсөлт орчихсон, нөлөөлчихсөн. Тэгээд одоо энэ чинь ер нь яах вэ, бид нар бол зүгээр нэг тойргийн асуудал биш шүү. Ер нь бол цааши цаашидаа аж ахуйн нэгжүүдийн өөрийнх нь асуудал шүү. Энэ аж ахуйн нэгжүүдийг.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа.

Т.Энхтүвшин: Батжаргал гишүүн түр байж байгаарай. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Засгийн газар 9 сарын 29-ний ажлын өдөр дуусаад төсвөө өргөн

барьчихсан байгаа. Тэгээд цаашаагаа төсөв дээр ялангуяа энэ нэмэгдлүүд орох, орохгүйг энд л шийдэх байх даа. Тийм бид нар хариулж мэдэхгүй байна. Тэр замыг ярихаар бас дахиад л заасан бол загнуулах байх даа. Бид нар чинь хуультай шүү дээ. Авто замын хуультай. Авто замын сангаас арчлалт, засварыг нь хийнэ гээд. Тэрнийх нь орлогоос хамаарсан л тэр зардлыг нь шууд тавьдаг. Хэрвээ орлогыг нь нэмэгдүүлж гэж байвал тарифыг нь нэмэх хэрэгтэй. Улсын төсвөөс 61 тэрбум, аймаг, орон нутгуудынх нь нийлээд нийлээд 173 тэрбум байгаа юм шүү.

Т.Энхтүвшин: Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Ерөнхийдөө нэлээн юмнууд тодрох ишг байна. Тэгэхээр төсвийн магадлалд аудит дүгнэлт хийсэн байна. Дүгнэлтийн дүнгээр 70 хэдэн тэрбум төгрөгөөр зөрсөн байна. Тэгээд тэр аудитын дүгнэлтээрээ 2024 оны төсвийн төсөлд суучхав уу, магадлалаараа суучхав уу гэдэг асуудлыг тодруулах ёстой гэж.

2 дахь зүйл аудитлагдаж чадаагүй 100 гаруй төсөл, арга хэмжээ хоцроод үлдчихжээ. Энийг бол Их Хурал үүрэх янзгүй. Юу гэж хэлэх гэж байна гэхээр зэрэг цаглавраа барьцаах л ёстой. Аудиталсан дүнгээрээ төсвийнх нь нэмэгдлийг тооцно гэж үзсэн бол төсөв өргөн барихаасаа өмнө бүх төсөл, арга хэмжээгээ аудитлуулаад, нэгдсэн дүнгээрээ л өргөн барих ёстой шүү дээ. Тэгээд одоо тэр үлдчихээд байгаа 100 гаруй төсөл, арга хэмжээ объект дотор чинь бараг 80, 90%-ийн гүйцэтгэлтэй бараг 100%-ийн гүйцэтгэл рүү дөхчихсөн ийм олон ажлууд байгаа шүү дээ. Тэгээд яах юм. Ирэх онд хөрөнгө суугаагүй гээд ингээд байгаад байх юм уу. Энэ дээр нэг тов тодорхой хариу Барилгын яам, Барилга хөгжлийн төв, холбогдох газруудад нь нэг хариу өгөөч гэж. Нэг ийм зүйл байна.

Дараагийн нэг зүйл байгаа юм. Энэ орж ирсэн салбарууд маань улс орны эдийн засгийн хөгжлийг түргэтгэдэг, баялаг бүтээдэг, салбаруудынхаа бодлого чиглэл, мэргэжлийн удирдлагаа хангаж явдаг гол салбарууд л байгаад байна л даа. Тийм учраас яг ирэх онд улсын төсөв ч гэдэг юм уу, гадна, дотнын зээл тусламж, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр эрчим хүчний хэчнээн мегаватт нэмэгдэх юм бэ. Зам дээр ер нь яг хэдэн километр зам нэмэгдэх юм бэ. Байж байгаа юмнуудаа бид бас арчилж, тордож авч явах ёстой. Тэгж байж насжилтыг нэмэгдүүлэх ёстой. Бид тэгж чадахгүй байгаад байна. Бүр зориуд бодлогоор зарим тохиолдолд төрийн бодлогоор улсын хөрөнгө устгаад байгаа байхгүй юу. Замынх нь ачааллаас давчихсан тэнхлэг дээр ирж байгаа ачаатай машин явуулах ийм үүрэг чиглэл өгөөд бүхэл бүтэн 400 гаруй километр зам эвдчихлээ шүү дээ. Эд нарыг чинь ер нь юу гэж ойлгох юм. Энэ стандартуудаа барих юм уу, барихгүй юм уу. Эндээс үүсэж байгаа хохирлыг ер нь цаашид яаж явна гэж бодоцгоогоод байна вэ. Тэгээд л орон нутгийн хэдэн дарга нар зайлуул газар гэсэхийн цагт тодорхой захирамж гаргаад шийдвэр гаргана. Төрийн бодлогод бараг замхруулсан, тээг болсон гээд халагдах, баривчлагдахдаа тулна. Үгүй ээ, ер нь явж явж тэр хэдэн хүн л жоохон хийгдсэн хөрөнгө оруулалт замыг чинь авч үлдээд байгаа шүү дээ. Яг үнэнийг хэлэхэд. Тэр бодлогоо барьж байгаа салбарууд нь энэ тал дээрээ сүйдтэй үр дүн гаргахгүй байгаад байгаа шүү дээ. Энийгээ ер нь яацаах юм. Тийм учраас энэ дээр нэг хариу авчихмаар байна.

Энэ зураг, төсөв боловсруулдаг энэ нэг юмнуудаа их л олон ярьж байгаа юм даа. Би хэд хэдэн газар ярьсан. Их тодорхой болгомоор байх юм. Барилгын яам одоо шинэ хуульдаа их тодорхой оруулж өгмөөр байна. Нэг маягийн зураг төсөвтэй гээд яриад байх. Тэгээд баахан шинэ зургуудад мөнгө үрээд байх. Энийг чинь юу гэж ойлгох юм. Тэгээд уг нь бол Барилгын сайд, Сангийн сайд 2 үнийн

өөрчлөлтийнхөө ерөнхий коэффициентыг батлаад тэрүүгээрээ төсөвт өртөгт нь өөрчлөлт ороод явах тийм л эрх зүйн зохицуулалт бидэнд байгаад байгаа юм байна лээ шүү дээ. Тэгээд тэрийгээ яагаад барихгүй байгаад байгаа юм. Тэгвэл хаа хаанаа амар байхгүй юу.

Дараагийн нэг хэлээд байгаа зүйл байгаа юм даа. Даваасүрэн сайдыг би анхааралдаа.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Батжаргал гишүүний микрофоныг 1 минут нэмээд өгье. Гүйцээгээд асуучих.

Ж.Батжаргал: Энэ гүйцэтгэгч магадлал хийлгэдэг юмыг больё та минь ээ. Тэр зохиогч, автор зураг хийсэн товаришууд. Тэр захиалагч 2 нь л магадлалынхаа юмыг ярьдаг бай. Тэгээд бүр нэг тийм гувшаа хурга шиг болчихсон юмнууд Барилга хөгжлийн төв, холбогдох яам дээр эргэлдээд явдаг энэ баахан гүйцэтгэгч нараасаа салах ёстой. Манай төрийн байгууллагууд. Тэр захиалж байгаа байгууллага нь түүнийг хийх норм нормативаар нь зураг төсвийг нь гаргасан тэр автор 2 нь асуудал үүссэн гэвэл магадлалаа хийлгэдэг л болох ёстой. Тэгж байж энд чинь арай дээр юм болно шүү. Үүнийг одоо энэ шинэ барилгын хуульдаа их тодорхой оруулж өгмөөр байна.

Дараагийн нэг зүйл төсвийн хуульд бид нар гайгүй шинэчлэл хийгээд, цаглавар юмнуудыг нэлээн ярьцаасан. Одоо бидэнд нэг орхичхоод байгаа юм байгаад байгаа юм билээ. Тэрийг Их Хурал нэлээн анхааралдаа авах ёстой. Энэ гүйцэтгэл тайлагнадаг үйл явцыг л бид нэлээн сайжруулахгүй бол болохгүй болчихоод байгаа юм. Тэндээс л нэлээн зөв юмнууд гарах ёстой. Бүр бараг салбар салбараар нь хэчнээн төсөл, арга хэмжээ бодлогын зорилтууд явсан юм. Тэрүүгээр нь ярьж хөөрдөг.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Даваасүрэн сайд хариулъя. Дараа нь Жавхлан сайд.

Ц.Даваасүрэн: Тэр нөгөө магадлан хийлгэх гээд яваад байгаа сая баруун талын хаалга дээр бас жагсаад байсан хүмүүсийн асуудлыг хөндөж байна л даа. Тэгэхэд тэр магадлангаа хийлгэх үү, аль төсөл дээр хийлгэх вэ. Хийлгэснийгээ төсөвтөө тусгах уу гэдэг чинь бол салбар яамдын л асуудал шүү. Боловсролын яам бол харин 60-аад төсөлдөө магадлан хийлгэе гээд манай Барилгын хөгжлийн газар бол ирүүлчихсэн юм байна лээ. Тэр нь бол 30 хэд нь магадлан хийгдээд явж байгаа. Тэгэхээр салбар яамдууд тэр магадлан хийлгэх үү, тэр хийлгэснийгээ тусгах уу гэдэг нь зөв. Батжаргал гишүүний хэлээд байгаа энэ бол үнэн шүү. Энэ яриад байгаа нөхдүүд дотор янз бүрийн хүмүүс үнэхээр ингээд үл бүтэхгүй төсвийг яах гэж авсан юм гэдэг асуудал байгаа шүү дээ. Тэртээ тэргүй 2009 оны ажиллах хүчний өртгөөр тооцчихсон байхад нь чи яагаад тендерт орсон юм гэж бас ярьж болно. Гэтэл бүтэхгүйг мэдсээр байгаад авчихсан. Тэгэхээр яадаг ч байсан авчихъя авсан хойноо нэмүүлье гэдэг юм байна гээд Батжаргал гишүүний хэлээд байгаатай бол би бас нэг талаараа санал нэгдэж байгаа. Тэгэхдээ нөгөө талаараа бас үнэхээр үнэн үү гэвэл үнэн. 2009 оны ажиллах хүчний төсөвт өртгөөр тооцчихсон байгаа юу, байгаа. Өнөөдөр ажиллах хүчний зардал хэд дахин өсчихсөн байгаа. Үнэн. Тэгэхээр энэ хүн ажлаа хийхэд хүндрэл учирч байгаа шүү дээ. Мэдээж хэн ирж хийх юм. 2009 оны тарифаар гэдэг ийм асуудлууд байгаа юм. Тэгэхээр миний түрүүний хэдэд байдаг асуудал бол ороод байгаа юм л даа. Төсөвт өртгөө тогтоогоод байгаа юмаа энэ аргачлалаа хэдүүлээ өөрчилье өө гэж. Энийг яаж тогтоодог болох вэ. Тендерээр тогтоож байгаа нь зөв үү гээд тэр бусад орны хэрэглээд байгаа тендерээр төсөвт өртгөө тогтоогоод байгаа руу явбал яасан юм. Тэгээд жишээлбэл, сургуулиудын хувьд, цэцэрлэгүүдийн хувьд, эмнэлгүүдийн хувьд жишиг зурагтай байна гэвэл тэгээд салбар нь шийдээд ерөөсөө ийм л жишиг зурагтай байна гээд л явна л даа.

Тэгээд л жишиг зургаа батлуулаад л тэгээд л явчих бололцоотой. Салбар нь өөрөө шийд тэрийгээ. Тэдэн ортой эмнэлгийн зураг бол энэ байна. Нээрээ тэгж олон зураг зуруулаад байх. 16 ортой гэж байгаа бол 16 ортой эмнэлгийг хэд хэдэн янзаар зуруулаад байх хэрэггүй шүү дээ. Улсын хэмжээнд ингэж гаргаад л тэрийгээ ингээд бусад юун дээрээ хийгээд явахад болохгүй юм бол байхгүй. Би бол тэрэнтэй бол санал нэг байна. Тэгэхээр би бол барилгын хуулийн оруулж ирэх гэж байгаа намрын хууль дээр бол төсөвт өртөг тогтоож байгаа тэгээд зургийн авторууд, экспертүүд хариуцлага хүлээдэг тогтолцоог бол өөр болгож өгнө. Харин та бүхэн энийг ёстой шийдэж өгөөрэй л гэж би хүсэх байна. Энэ төсөвт өртгийг нэмж байгаа, тэр зурагт өөрчлөлт оруулж байгаа үүгээрээ ямар нэг хариуцлага хүлээхгүй байна шүү дээ. Байгаа л гэж байгаа боловч хариуцлага хүлээнэ гээд биччихээд яг ямар хариуцлага хүлээх вэ гэдгээ тодорхой зааж өгөхгүй байгаа ийм зүйлүүд байгаад байгаа учраас ер нь та бүхэн ингээд харвал ер нь барилгыг бол ашгийн талбар гэж хараад байна шүү дээ. Тэрнээс биш тэр барилгыг барьж байхдаа гадаад орчин нь хүний аюулгүй байдлыг хангаж байна уу, үгүй юу, тэнд хамгаалалт тавьж байна уу, үгүй юу гээд харах юм бол дийлэнх байшин ямар ч хамгаалалт тавихгүй байна шүү дээ. Барьж байгаа байшингууд. Хэмнэж байна шүү дээ тэр мөнгийг. Нөгөө талаараа тэнд хөдөлмөр аюулгүй байдал хангагдаж байна уу. Үгүй. Тэнд хүн бэртэж байна уу, тэрэнд ямар хариуцлага хүлээж байна гээд иймэрхүү юмнуудыг барилгын шинэ хуульд бол хатуу болгож өгнө. Тэгээд жоохон хариуцлагажуулахгүй бол ерөөсөө яг үнэн. Энэ чинь одоо хэдэн жил ярих юм бэ. Аль намайг Сангийн яаманд байж байх үеийн яриа өнөөдөр яригдаад явж байна шүү дээ. Тийм учраас энэ барилгын салбарт гараад байгаа яг энэ зүйл дээр бол би цэг тавихын төлөө байна. Тийм учраас хуулийн өөрчлөлтүүдийг нь хийж

байна. Олон улсын туршлагыг бид нэлээн судалж байна. Тэгээд орж ирэхээр нь харин та бүхэн ёстой сайн хэлэлцээд энийг шийдэж өгөөрэй.

Т.Энхтүвшин: Сангийн сайд.

Б.Жавхлан: Батжаргал гишүүний асуултад нэмж хариулъя. Юуны тулд бид нар аудитлуулж байгаа билээ. Аудитын дүнгээр авалгүй яах вэ. Магадлан нэг бүрийг ийш нь явуулж байгаа. Тэгээд яг дүн ирэх юм бол энэ чинь бас аудит дээрээ нэмэгдэж байгаа юмнууд ч байгаад байгаа шүү. Нэмэгдэж байгаа нь 50,9 тэрбум, бууруулсан нь 91 тэрбум. Зөрүү нь 40 тэрбумаар буурч орж ирж байна гэсэн үг. Магадлангийн дүнгээсээ нийт дүн нь. Тэгэхээр аль болох бага дүнгээр нь авахыг л бид зарчим болгож явж байгаа. Тэр хоцорсон зүйлүүдийг бол ёстой мэдэх юм алга тийм.

Т.Энхтүвшин: Туваан гишүүн.

Ц.Туваан: Яамдууд бас тодорхой хэдэн асуулт асууя. Эртээд би бас Сангийн яамныхнаас асуусан. Хөдөө аж ахуйн яамныхан хариулчхаарай. Хөдөө аж ахуйн гаралтай ноос ноолуур, ноос, арьс шир, сүү, хүнсний ногоо, улаан буудайн урамшуулал дээр яг хэдэн төгрөг энэ жил тавигдсан бэ. Хэдэн тэрбум төгрөг. Төсвийн ном дээр харагдахгүй байна. Энийг яагаад асууж байгаа гэхлээр малчид руу чиглэсэн нийгмийн даатгалын хуультай холбоотой асуудлууд яригдаж байгаа. Малчдын НДШ-ийн 50 хувийг төрөөс хариуцахаар, дээрээс нь төрөөс олгох урамшууллаас эрүүл мэнд, НДШ суутган тооцох гээд хууль 10 сарын 1-ээс хэрэгжээд эхэлчихсэн. Засгийн газар дээр орсон л гэсэн, журам албажаагүй гээд ингээд яваад байгаа. Энэ албажсан уу. Танай сайдын багц дээр энэ асуудлуудыг ялангуяа 2 дахь хуулийн асуудлыг бол Хөдөө аж ахуйн яам хариуцаж хийнэ. Тэгэхээр энэ дээр хууль сурталчлах зардал гэж танай дээр тавигдсан юм ер

нь байна уу. Энийг ер нь яаж сурталчилж хамрагдалтыг нь нэмэгдүүлэх гэж байна гэсэн ийм асуулт байна.

Мал эмнэлгийн асуудал бол Бат-Эрдэнэ гишүүн ерөнхийд нь асуучихсан. Тэр нөгөө хүнсний хангамж, аюулгүй байдал 1 их наядын. Яг 2023 оны өнөөдрийн 10 сарын байдлаар гүйцэтгэл хэчнээн тэрбум төгрөгийн зээл гарсан бэ. Энэ ээлийн хүүгийн маржид тавигдсан мөнгийг яг хэд нь гараад ашиглаж байна. Ирэх 2024 оны төсөв дээр хэдийг тавьж байгаа вэ. Нөгөө төрөөс олгох хүүгийн маржид. Энийг нэг тодорхой хариулаадхаач.

Өртөг шингэх болсон нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг хамгийн их үйлдвэрлэж байгаа хүмүүс чинь малчид шүү дээ. Хөдөө аж ахуйн салбарынхан байна. Ногоочид, тариаланчид. Тэгээд энэ хүмүүсийн тэр бэлдээд өгч байгаа тэр арьс шир ноос ноолуур энийг боловсруулах гээд нэг юм ярьдаг юм. Дарханы арьс ширний цогцолбор. Тэгээд танай яам яадаг вэ гэхээр явж байсан юмыг шууд зогсоогоод, шинээр юм үүсгээд, тэгээд дахиад эхэлнэ гээд ингээд яриад явдаг. Тэгээд харин дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг явж байна гэсэн. Энэ ер нь юу болсон юм бэ. Тэгээд энэ дээрээ олигтойхон төсөв тавиад энэ ажлаа гүйцээгээдхээч. Малчдын чинь бэлтгэсэн түүхий эд ёстой гуу жалганы нэгээр боллоо шүү дээ. Тэгээд явж байгаад дараагаар нь болохоор асуухаар Эмээлтийн цогцолбор энэ тэр гээд ингээд төөрөөд яваад өгдөг. Энэ асуудлыг хариулж өгөөч. Малчидтай холбоотой юм дээр тэр малчдыг НӨАТ төлөгч гээд НӨАТ-ын татвараа мэдүүл гээд ингээд бөөн юм яриад, ойлгомжгүй юм яриад явчихдаг энэ дээр хуульд өөрчлөлт оруулах юм яриад байсан энэ асуудлыг бас хариулж өгөөч.

Зам, тээврийн яамнаас, Төв аймагт явагдаж байгаа энэ жил замууд харин бас харьцангуй тавигдаж байгаа.

Тэгээд энэ дээр Батсүмбэрийн зам дээр тэр ахмадын төвийн дарга нь хүсэлт тавиад, бид нар бас уламжлаад ингээд ярьсан. Ашгүй тэр хойгуур буюу тэр араараа явах ийм боломжтой болж өгсөн. Энэ дээр төсвийг нь нэмэгдүүлэх боломж байгаагүй юу. Арай бага байгаа юм шиг санагдаж байна.

Аудитаас бас нэг асуулт асууя. Тэр Жаргалантаас эхлээд Шар Хөтөлөөр дамжаад хойшоо Хөтөл рүү явж байгаа зам байгаа. Энэ дээр аудит дээр юм юу гэсэн бэ, түрүүн төсөв тавигдаагүй гэж хэлчих шиг болох юм. Энэ асуудлыг яг би буруу сонсчхов уу, энэ дээр нэг тодорхой хариулт аудитынхаа өгөөдхөөч.

Монгол Улсын Ерөнхий сайд Төв аймагт ажиллах хугацаанд Төв аймгийн Бүрэн сумын авто замыг барина гэдэг амлалтыг өгөөд явсан. Төсөв дээр харагдахгүй байх юм.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд.

М.Ганхүлэг: Туваан гишүүний асуултад хариулъя. 5 асуулт байна. Товчхон хариулаад явъя. 2024 оны улсын төсөвт 5 төрлийн урамшууллыг Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас олгохоор байгаа. Нийт дүнгээрээ бол 78,4 тэрбум төгрөг гэж орж ирж байгаа. Малчдын хувьд бол сүүний урамшуулал, арьс ширний урамшуулал, ноосны урамшууллыг үргэлжлүүлэн олгохоор тусгасан байгаа.

2-т нь хууль сурталчлахтай холбогдолтой зардал арга хэмжээ энэ дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр тодорхой нийгмийн асуудалтай холбогдолтой хуулийн зардлууд нь бол суугаад, манай дээр бол 6 төрлийн багц хуулийн ажлын хэсгүүд нь хэлэлцээд ингээд явж байгаа. Ургамал хамгаалал болон хорио цээртэй холбогдолтой хуулийн төслийг бол өргөн барьсан байгаа. Бусад хуулийн ажлын хэсгийн

дүгнэлтүүд нь гарч дуусахаар өргөн барихаар байгаа.

3-д нь хүнсний хангамж, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх 36 дугаар тогтоолын хүрээнд энэ жил 932 тэрбум төгрөгийг бол төсөвлөсөн байгаа. Үүнээс бол 524 тэрбум төгрөг нь буюу 50-60%-ийн гүйцэтгэлтэй байгаа юм аа. Ирэх жил 136,2 тэрбум төгрөгийг үндсэндээ бол төсөвлөсөн байгаа. Энэ жил 1800 орчим компани урамшууллын зээлд хамрагдаад, үйл ажиллагаагаа бас явуулахаар болсон байгаа.

4 дэх асуулт нь боловсруулах үйлдвэртэй холбогдолтой асуудал байгаа. Хүнс, хөдөө аж ахуйн яам дээр Хөгжлийн банк болон хувийн хэвшилтэй хамтарсан ажлын хэсэг байгуулагдаад, тодорхой дүгнэлтээ гаргаж ирсэн байгаа гишүүн ээ. Хамгийн гол нь бол одоогийн хийгдсэн байгаа хувийн хэвшлийн 6 дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хүлээн авах юм бол ямар дүнгээр авах вэ гэдэг тоо бол Барилга хөгжлийн төв болон Эрчим хүчний төвөөрөө баталгаажсаад ингээд гарсан. Одоо энэ дүнгийн дагуу хүлээлцэх асуудлыг Хөгжлийн банк болон хувийн хэвшил хоорондоо хэлцэл хийх, ТУЗ-үүд нь хуралдаж байгаа ийм процессынхоо үйл ажиллагаа дээр явж байна. Энэ 2024 оны төсөв дээр энэхүү цогцолборын цэвэрлэх байгууламжийн төсвийг нэмэлтээр суулгасан байгаа. 21,3 тэрбум төгрөгийг суулгасан байгаа.

НӨАт-тай холбогдолтой асуудал ярилаа. Төсвийн тухай хуулийн дагах хуулиудын хуулиуд дээр чөлөөлөх байдлаар тусгагдаад, төсөл байдлаар явж байна. НӨАТ-аас чөлөөлнө. Таны саяын ярьсан яг малчдын ноолуур болон бусад түүхий эдтэй холбогдолтой бүх асуудлууд дээр НӨАТ-аас чөлөөлөх байдлаар орохоор байгаа.

Т.Энхтүвшин: Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Халтар. Батсүмбэрийн замыг асуулаа шүү дээ.

Л.Халтар: Туваан гишүүний асуултад хариулъя. Төсөвт орчихсон 10,7км нийтдээ 13,3 тэрбумтай, 2024 онд 4 тэрбум төгрөгийн ажил хийгдэнэ. Тэгэхдээ юу шүү дээ Туваан гишүүн ээ, нөгөө хуучин сайжруулсан далантай. Тэгээд өөрөөр хэлбэл 1,2 орчим тэрбум төгрөг. Тэгээд одоо нөгөө экспертизээр ороод батлаад гаргаад ирсэн учраас бид нар бол нэмнэ, хасна гэж хэлэхэд жоохон хэцүү шүү. Тэгэхдээ сайжруулсан далантай. Далан дээрээ хийгээд явчихад нөгөө толгойн зүүн урд талд нэг жоохон өөрчлөлт гарвал гарна, бусад нь далан нь сайн учраас гайгүй болчих болов уу л гэж бодож байна.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон. Тэр Бүрэнгийн зам гэж байна.

Л.Халтар: Бүрэнгийн зам гэж юм ороогүй. Манай дээр ирээгүй байна. Бид нар бол ирсэн бүх саналуудыг л Сангийн яам руугаа явуулсан даа.

Т.Энхтүвшин: Сангийн яам. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Ч.Чимдсүрэн: Туваан гишүүний асуултад хариулъя. Сангийн яам, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чимэдсүрэн. Төв аймгаас Бүрэн сумын чиглэлийн авто замын зураг төсөл, ТЭЗҮ нь хийгдээгүй. Энийг бол шийдвэрлэе гэдэг ийм зарчмын хувьд гарсан учраас Эдийн засаг, хөгжлийн яамны зураг төсвийн багцаас ТЭЗҮ зураг төсвийг нь хийхээр 2024 онд гарахаар Засгийн газрын тэмдэглэл гарсан байгаа. Тэгэхээр зураг төсөв нь хийгдэнэ гэсэн үг.

Т.Энхтүвшин: Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Төрөөс олгох урамшууллын асуудлыг Хөдөө аж ахуйн яам хариуцахаар байгаа гэсэн шүү. Тэр журмаа сайн уншаад өөрсдөөсөө зайлуулалгүй малчдын асуудал бас аваад

яваарай гэдгийг хэлье. Бас Зам, тээврийн яамнаас сая минут хүрээгүй тодруулаад асуучихъя. Мөнгөнморьтын зам маш удаж байгаа. 2 компани байгаа 2 дахь хэсгийн нөхдүүдийг нь сонгон шалгаруулна гээд л ингээд яваад байсан. Энэ ер нь юу болчхов. Дараагийн асуудал. Дарханы зам. Одоо бол нээрээ явахад маш төвөгтэй. Орон нутгаас иргэд маш олон асуудал ярьж байгаа. Зам тэмдэглэл, тэмдэглэгээ нэг явж байснаа гараад л нөгөө талд орчихдог, нэг мэдсэн эсрэг урсгалд орчихсон энэ тэр асуудлууд яваад байгаа. Тэгээд энэ чинь хэзээ дуусах юм бэ. Энэ одоо нэлээн олон жил болж, нэлээн олон хүний амь нас, техник тоног төхөөрөмж үрэгдсэн асуудал боллоо шүү дээ.

Т.Энхтүвшин: Халтар сайд. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Л.Халтар: Мөнгөн морьтын зам аргагүй, удсан. Тэгээд ирэх жил 2024 онд бол бид нар дуусахаар төсөв дээр мөнгийг нь тавиад өгсөн. 2 компанийн хооронд маргаантай асуудлууд байсан. Нэг ийм шийдэгдэж байгаа юм байна. Ирэх жил дуусна. Дарханы замын хувьд тийм зүйл байгаа. Арай жоохон өвөрмөц зам, нөгөө өнгө хучилтууд, суурь хучилт, өнгө хучилтууд явагдаж байгаа учраас 1 талын 2 урсгалыг хаагаад, нөгөө талын 2 урсгалаар 2 чиглэлийн хөдөлгөөнийг хийгээд яваад байгаа учраас тийм зүйлүүд байна. 11 сарын 5-ны дотор багтаагаад бид нар 4 эгнээгээр замынхаа хөдөлгөөнийг бүрэн нээнэ. Одоо бол яг хөвөөний ажил тэмдэг тэмдэглэгээ, цагаан зураас, тэгээд өнгө хучилтын үлдэгдэл жоохон ажлууд явагдаж байна. Сая өнгөрсөн 7 хоногт яваад ирсэн. Маргааш бас ажиллах гэж байна. Ингээд бол 11 сарын цаад талын хугацаа 11 сарын 5 гэхэд бол 204км 4 урсгалтай замаа бол 4 эгнээгээр нь.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Боомтын сайдаас энэ боомтын сэргэлт гээд явж байгаа. Тэгээд Төв аймаг дээр хуурай боомт гэж ярьдаг. Энэ асуудлууд бол тань дээр байгаа байх. Тэгээд энэ ямар маягаар ямар байдлаар ажил нь явж байгаа вэ. Төсөв дээр ер нь орж ирж тусгагдаж байгаа юм байгаа юу. Барилгын юун дээр тэр хүн болгон л хэллээ дээ. Тэгээд 1 тод жишигээг нь би хэлчихье. Төв аймгийн Лүн, Угтаалцайдам сумдын цэцэрлэг баригдаад дуусчихсан. Тэгээд хүлээж аваад хүүхэд орох боломж байхгүй энэ цэцэрлэгүүд дээр. Яасан гэхээр нөгөөдүүл нь тэр байшингаасаа цаашаа гарах шугам сүлжээ, цахилгаан, дулааны асуудал тавих юм ерөөсөө байхгүй болчихсон. Тэгээд барилгууд нь ингээд шинээрээ цонх нь хагараад байж байдаг. Тэгээд ирэх жилийн төсөв дээр тавигдаад хийгдэхээр байгаа юм. Тэгэхээр энэ асуудлыг бүгдээрээ ер нь хамтдаа бас нэлээн том асуудал болгож ярьсан.

Т.Энхтүвшин: Тулга сайд. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Б.Тулга: Туваан гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр олон улсад бүртгэлтэй байгаа Монгол Улсын 4 хуурай боомт байгаа. Энэ дээр нэмээд Төв аймгийг, мөн Ховдыг нэмж оруулахаар Зам, тээврийн яам дээр ярьж байгаа. 11 сард болох олон улсын хурал дээр бол энэ шийдвэр гарах байх. Ингээд гараад ирэх юм бол Хөшигтийн хөндий маань өөрөө хуурай боомтын бүртгэлтэй болж, цаашаа хөгжин явах ёстой байх. Яг одоогоор хуурай боомтын асуудал бол Зам, тээврийн яам дээр харьяалалтай байгаа.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон. Халтар сайд.

Л.Халтар: Хуурай боомтын асуудал эзнээ олох гэж хэдэн жил жоохон будилсан нь үнэн. Гадаад хэргийн яам дээр хүртэл нэг хэсэг явсан. Үндэсний хороо. Ингээд 2022 оноос

эхлээд Зам, тээврийн хөгжлийн яам руу шилжиж ирсэн. Бид нар далайн захиргааны дэргэд хуурай боомт эрхэлсэн нэгжийг байгуулаад дотор нь орон тоо нэмэхгүйгээр ингээд явж байна. Хамгийн түрүүн одоо үндсэндээ 8 газар хуурай боомт байгуулах боломж нь бүрдсэн. Хамгийн эхнийх бол бид нар Замын-Үүд гэж харж байгаа. Бид нар 11 сард тээврийн 7 хоног зохион байгуулна. Энийг бид нар зүгээр төрийн ямар нэгэн оролцоогүйгээр төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд цаашид зохион байгуулъя гээд ер нь бол концесс зарлаж гэдэг дээр яам дээрээ бол санал нэгдээд ингээд явж байгаа. Замын-Үүд бол хамгийн түрүүнд, тэгээд Сайншанд саяын түрүүний Тулга сайдын хэлдэг Хөшигийн хөндий, Чойбалсан, Ховд гээд ингээд явах юм. Тэгээд энэ дотроосоо хамгийн түрүүн.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Би нэг асуулт, санал хэлье. Үйлдвэр технологийн паркийн тухай хууль гэж 2022 оны 8 сарын 1-нд батлагдаад, мөрдөгдөөд явж байгаа. Үйлдвэр технологийн паркийн тухай хуулийг дагалдуулаад Гаалийн татварын болон Гаалийн тарифын тухай хуульд өөрчлөлт орсон. Үйлдвэр технологийн паркаар зарлагдсан бүсүүдэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын импортын татварыг чөлөөлөхөөр, Нэмэгдсэн өртгийн албан татварыг 4 жил хүртэлх хугацаагаар хойшлуулахаар ийм заалт гарсан. Монгол Улсын Засгийн газар 7 сарын 5-нд Үйлдвэр технологийн паркийн байршил, үйлдвэр технологийн паркт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын нэрсийг Засгийн газар зарласан. Ингээд 3 сарын дараа 1 журам гарсан. Дагалдах журам гарсан. Харамсалтай нь үйлдвэр технологийн парк зарлагдсанаас хойш энэ бараа материал бол орж ирсэн. Үйлдвэр технологийн паркт үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд маань гаалиар бараа бүтээгдэхүүнээ оруулж ирсэн. 3 сарын дараа журам гарсан. Харамсалтай нь нөгөө үйлдвэр

технологийн паркаар үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь импортын татваруудаа одоо хүртэл төлөөд яваад байна. Төлөөд яваад байна. Бид нар журам гаргах гэж 3 сарын дараа ингэж гаргасан. Эндээс өмнө компаниуд зарлагдсанаас хойш бараа материалуудаа оруулж ирсэн. Тэгээд энэ асуудал дээр тодорхой хариулт хэлж өгөөч. Яагаад үйлдвэр технологийн паркаар зарлагдсан бүсүүдэд энэ компаниуд импортын татвараа төлж яваад байгаа юм. Яагаад энэ хуулийн хэрэгжилтийг хангахгүй байгаа юм. Бид нарыг журам гаргасныг хүлээгээд энэ компаниуд юмаа оруулж ирэхгүй байна гэж байхгүй шүү дээ. Тэгээд энэ тал дээр бас нэлээн тайлбар хэлж өгөөч. 3 төрлийн л татвар байж байгаа шүү дээ. Барилгын материалууд, дэд бүтцийн материалууд, тэр тоног төхөөрөмжийн материалуудыг ингээд импортын татвараас чөлөөлөх л асуудал байж байгаа. Тэгээд яамдын уялдаа холбоо маш муу байна. Үнэхээр муу байна. Үйлдвэр технологийн паркаар зарлагдсан 2 компани бол үнэхээр зовлонгоо эдэлж байна. Шинэ сэргэлтийн бодлого гээд бид нар ярьсан. Ажлын байрыг нэмэгдүүлбэ, эцсийн бүтээгдэхүүн хийе гээд 2 коксын үйлдвэр, 1 ширэмний үйлдвэр, 1 гангийн үйлдвэр, нүүрс хуваах үйлдвэр ингээд хорголжин төмрийн үйлдвэр, эрчим хүчний үйлдвэр гээд Монголд анх удаагаа ийм ажлын байрыг нэмэгдүүлсэн эцсийн бүтээгдэхүүн хийдэг Монгол Улсын Засгийн газар Улсын Их Хурлын гишүүдийн яриад байдаг энэ 2 том хувийн хэвилийн үйлдвэрүүдийг л ингээд яагаад дэмжиж өгөхгүй байгаа юм бэ. Би энэ 3 яам байгаа учир л ингэж хэлээд байна шүү дээ. Яагаад ингээд бие бие рүүгээ явуулаад байгаа юм. Энэ компаниуд бол аягүй хүндрэлтэй байна. Тийм учраас та хэд журам чинь ер нь хэрэгжиж байгаа юм уу, хэрэгжихгүй байгаа юм уу гэдэг дээр нэг тайлбар хэлээдхээч. Энэ компаниуд чинь импортын татвараа төлөөд явж байна. Яагаад бид нар ингээд шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд үйлдвэр технологийн

парк гэж зарлагдаад, хуульд орсон өөрчлөлтүүдээ, татварын хөнгөлөлтүүдээ эдэлж чадахгүй байна гэдэг ийм асуудал яриад байна. Тийм учраас энэ журам хэрэгжиж байгаа юм уу, хэрэгжихгүй байгаа юм уу гэдэг дээр надад нэг тодорхой хариултыг хэлж өгөөч. Уул уурхайн яам, Сангийн яам Эрчим хүчний яам, Барилга, хот байгуулалтын яам энэ дээр хэлж өгөөч ээ. Үнэхээр энэ асуудлыг шийдэхгүй бол Үйлдвэр технологийн паркийн тухай хуулийн хэрэгжилт үндсэндээ бол хангагдахгүй нь ээ. Ийм асуултыг асууя. Дараалаад энийг хариулаад өгөөч. Энэ аж ахуйн нэгж, байгууллагуудаа дуудаж уулзаад, хөрөнгө мөнгөө гаргаад, ажлын байрыг нэмэгдүүлэх гээд ингээд зүтгээд байгаа компаниудаа жосохон дэмжээд, дэм болоод өгөөч л гэж хүсэж байгаа юм. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

Б.Тэлмүүн: Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн. Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40.4 дэх заалтын дагуу Үйлдвэр технологийн паркийн удирдлага нэгжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар 1 удаа сунгах шийдвэрийг Засгийн газар гаргаж болно гэж заасан. Өөрөөр хэлэх юм бол парк байгуулагдмагц тэд паркийн импортын тоног төхөөрөмж барааг чөлөөлнө гэж бол хууль заагаагүй. Энэ хуулийн дагуу Засгийн газрын 2023 оны 9 сарын 13-ны өдрийн 337 дугаар тогтоолоор бол хэсэгчлэн төлөх, гаалийн татвар төлөх хугацааг сунгах, чөлөөлөх журмыг бол баталсан байгаа. Өмнө нь хэрэгжиж байсан болон хуульд заасны дагуу бол гаалийн татварыг хэсэгчлэн төлүүлэх асуудлыг бол Гаалийн байгууллага, Сангийн яам салбарын асуудал эрхэлсэн яам импортлогч гэрээгээр зохицуулж

байгаа. Өнөөдрийг хүртэл бол Сангийн яаманд аливаа үйлдвэр технологийн паркийн татварыг хойшлуулах, хэсэгчлэн төлүүлэхтэй холбоотой санал салбарын яамдаас ирээгүй байна.

Таны яг асуусан асуулттай холбоотойгоор журмын 1.2-т хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш хугацаанд гаалийн баталгаат бүсэд байршуулж, гаалийн хилээр нэвтрүүлээгүй бараанд энэ журам үйлчилнэ гэж заасан. Тэгэхээр хууль хүчин төгөлдөр болсон 2022 оны 7 сарын 5-аас хойш энэ журам үйлчлэх хуулийн боломж нь бол байгаа. Засгийн газар хэрвээ тухайн паркт гаалийн татварыг хэсэгчлэн төлүүлэх шийдвэр гарсан тохиолдолд Гаалийн тухай хуульд заасны дагуу хууль хэрэгжсэнээс хойш оруулсан барааг чөлөөлөх, сунгах эсэх асуудлыг бол шийдвэрлэн явах бүрэн боломжтой байгаа. Хариулж дууслаа.

Т.Энхтүвшин: Уул уурхайн яам. Ер нь бол Уул уурхайн яамны л гол ажил шүү дээ. Уул уурхайн бүтээгдэхүүнээ эцсийн бүтээгдэхүүн болгох, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудал. Тэгээд Сангийн яамтайгаа уялдаа холбоотой ажиллах, санал, хүсэлтээ Сангийн яаманд өгөх энэ асуудал дээр нэлээн хойрго хандаад байгаа шүү. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон. Магнайсүрэн дарга.

С.Магнайсүрэн: Энхтүвшин даргын асуултад хариулъя. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Магнайсүрэн. Үйлдвэр технологийн паркийн эрх зүйн байдлын хууль энэ оны 8 сарын 1-ээс хүчин төгөлдөр болсон.

Т.Энхтүвшин: 2022 оны 8 сарын 1 шүү.

С.Магнайсүрэн: Аан тийм. Энэ хуулийн хүрээнд бид нар 10 дүрэм журам гаргах ийм үүрэг хүлээсэн. Өнөөдрийн байдлаар бол 5 дүрэм журмыг нь гаргаад

хэрэгжилтийг нь бол хангаж байна. Одоо яг бидэн дээр 5 журам гаргахаар боловсруулагдаж байгаа.

Нэг нь бол Үйлдвэр технологийн паркийн газрыг тусгай хэрэгцээнд авахтай холбоотой ийм асуудал байж байгаа. Энийг Барилга, хот байгуулалтын яамтай хамтарч бид нар ойрын хугацаанд шийдвэрлэхээр зорьж байна.

Дараагийнх нь бол үйлдвэр технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх хяналт тавих журам. Мөн энэ паркийн байршил, парк дээр эрхлэх үйлдвэрлэлийн салбар, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүний төрлийн жагсаалтыг батлах, паркийн мэдээллийн сан үүсгэх, хөтлөх журам гэсэн ийм журмууд байгаа юм. Тэгээд бид нар ойрын хугацаанд энэ саяын дурдсан журмууд дээр ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Манай сайдыг гадаад томилолт дуусаад ирэх үед нь визэнд гаргахаар энэ бүтээгдэхүүний төрлийн жагсаалт батлах асуудал бол бэлэн болсон байж байгаа. Тэгээд ер нь бол паркийн асуудал дээр бид нар шуурхай арга хэмжээ авч ажиллахаар ингэж бол тооцоолж байгаа. Ажлын хэсэг гарсан ажиллаж байгаа. Тийм учраас Байнгын хороонд бол бид нар энэ талаар ойрын хугацаанд шуурхай мэдээлэл өгч ажиллах ийм бололцоотой байна. Яг өнөөдөр бол бид нар үйлдвэр технологийн паркийн зөвшөөрөл авсан “Гэрэлт говь”, “Алтаниширээт” гээд энэ 2 паркийн удирдлагууд, хүмүүстэй нь өнөөдөр 2 цагаас уулзахаар Уул уурхайн яам дээр уулзалт зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Дээр нь саяын Сангийн яамны хэлдэгчлэн татварыг хэсэгчлэн төлөх, сунгуулах хүсэлттэй холбогдуулаад холбогдох баримт бичиг материалаа ирүүлнэ үү гээд бид нар 10 хоногийн өмнө энэ 2 байгууллагад албан бичиг өгсөн байж байгаа. Өнөөдрийн байдлаар манай яаманд ирсэн материал, хүсэлт байхгүй байгаа. Тийм учраас бид нар өнөөдөр энэ

уулзалтаараа нэлээд асуудал шийднэ гэж ингээж тооцож байгаа. Баярлалаа.

Т.Энхтүвшин: Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш энэ үйлдвэр технологийн паркаар зарлагдсан аж ахуйн нэгж, байгууллагууд энэ хөнгөлөлт, чөлөөлөлт, татварын юу гэдэг юм сунгалтаа эдлээд явна гэж ойлголоо шүү дээ. Тэлмүүн дарга аа тээ.

Зарчмын зөрөөтэй саналтай гишүүд байхгүй байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийсэн талаар Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна. Монгол Улсын 2024 оны төслийн 2 дахь хэлэлцүүлэг хэлэлцэж дууслаа.

Ажлын хэсгийн гишүүддээ бас баярлалаа.

12.19 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. Гишүүдээ дуудаарай.

Ажлын хэсгийн удирдамж батлах тухай, Ажлын дэд хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 19 дүгээр тогтоолын хэрэгжилт болон ноос, ноолуурын боловсруулалтын түвшинийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор Улаанбаатар хот, орон нутагт хялгас ялгах аас дээш боловсруулалт хийх үйлдвэрүүдийн хүчин чадал, суурилагдсан тоног төхөөрөмжийн талаар хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 2023 оны 5 дугаар тогтоолоор баталсан. Өнөөдрийн хуралдаанаар ажлын хэсгийн ажиллах удирдамж болон ажлын дэд

хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 8.3-д ажлын хэсгийн хяналт шалгалт хийх үйл ажиллагааны удирдамжийг Байнгын хорооны тогтоолоор батлах тухай ажлын хэсэг, уг тогтоолд заасан хугацаанд санал, дүгнэлт гаргаж Байнгын хороонд танилцуулна гэж заасан байгаа. Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд бас тараасан. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол

“Ажлын хэсгийн удирдамж батлах, ажлын дэд хэсэг байгуулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.10, 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны 5 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 19 дүгээр тогтоолын хэрэгжилт болон ноос, ноолуурын боловсруулалтын түвшинийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор Улаанбаатар хот, орон нутагт хялгас ялгах аас дээш боловсруулалт хийх үйлдвэрүүдийн хүчин чадал, суурилагдсан тоног төхөөрөмжийн талаар хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсгийн удирдамжид заасан хугацаанд хяналт шалгалтыг зохион байгуулж, тайлан, санал, дүгнэлт боловсруулан Байнгын хорооны хуралдаанд 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр багтаан танилцуулахыг ажлын хэсэг /Ж.Батжаргал/-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга, ажлын хэсэг хяналт тавьж ажиллахыг Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга /Т.Энхтүвшин/-д даалгасугай.

Үйлдвэрчдийн бодлогын байнгын хорооны дарга Т.Энхтүвшин гэсэн ийм тогтоолын төсөл байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. Туваан гишүүн. Туваан гишүүний микрофоныг өгье.

Ц.Туваан: Баярлалаа. Ажлын хэсэг бол батлагдчихсан байх тээ. Удирдамж батлах. Энэ дээр зүгээр нэг зүйл анхааруулаад хэлчихье гэсэн юм. Яагаад юу гэхээр бид нар ноолуур дээр нэг шийдвэр гаргасан тээ. Манайх нөгөө самнах гээд тэгээд яваад буцаад нөгөө юу яачихсан. Энийгээ хүчингүй болгочихсон. Ноолуур дээр. Тэгэхээр энэ дээр ямар чиглэлтэй явж байгаа вэ. Хэдүүлээ бас нэг Байнгын хороо байна нөгөө гаргасан шийдвэр маань хэрэгжих гэж явж байгаад зогсоод тэгээд бүр Засгийн газраас бараг шийдвэр нь цуцлагдаад тийм ээ, тэгээд энэ болохоор нөгөө ноолуурын үнэд нөлөөлөх шийдвэр байхгүй юу. Тэгэхээр энэ дээр ер нь дарга ямар байр суурь бодлоготой явах юм бэ. Одоо хүмүүс асуугаад байгаа. Бас дээрээс нь нөгөө ноолуур бэлтгэн нийлүүлдэг ченжүүд гэж ярьдаг тэр хүмүүс асуугаад байгаа. Тэгээд аль талдаа ямар саналууд гараад энэ буцаад ингээд гацчихсан юм бэ. Миний хувьд бол бид нарын манай Байнгын хорооны зарчим чинь бол өртөг шингээх, нэмүү өртөг шингээх, үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх гэдэг бодлогоо ингээд шатлаад ахиулаад

явмаар санагддаг юм. Энэ дээр та нэг тодруулж хэлж өгөөч.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн дарга Батжаргал гишүүн. Батжаргал гишүүний микрофоныг өгөөрэй.

Ж.Батжаргал: Тэгэхээр Улсын Их Хурлаас яг энэ чиглэлээр 2022 онд тогтоол гарчихсан юм. Самнахаас дээш боловсруулалт хийсэн ноос ноолуурыг гадагш нь гаргана гээд тэр шийдвэр хэвээрээ байгаа. Засгийн газар бол гагцхүү өнөө биткус батлаагүй хойшлуулчихаад байгаа ийм зүйл бий. Тэр асуудал бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам 2 дээр байж байгаа суурь судалгаанууд зөрүүтэй юм билээ. Тэрнээс болоод асуудал үүсээд байгаа. Тийм учраас ерөөсөө улсын хэмжээнд ноос ноолуурыг угаадаг, тэгээд самнадаг 48 үйлдвэр байна гэж. Үүний яг газар дээр нь бүгдийг нь яваад үзчихье. Тэрнээс 4 нь хөдөө, бусад 40 хэд нь Улаанбаатар хотод байгаад байгаа юм. Тэгэхээр зэрэг яг суурилагдсан хүчин чадал хэд юм бэ. Одоо ямар үйл ажиллагаа явуулаад байгаа хүмүүс юм бэ, жилд хэдий хэмжээний ноолуур бэлтгэж аваад тэгээд ямар боловсруулалт хийгээд гаргаад байна вэ гэдэг асуудал. Энэ бүх юмнуудыг нь бүгдийг нь нэг үзээд, тэгээд Байнгын хороо дээрээ бүх мэдээлэл, тайлангаа тавиад, дүгнэлтээ тавиад, тэгээд эндээс Засгийн газарт тодорхой чиглэл өгч, Их Хурлын тэр шийдвэрийг хэрэгжүүлэх эсэх асуудал дээр нь тодорхой чиглэл өгье. Энэ ингэж удаашируулаад байх хэрэггүй. Ер нь бол ноолуурын боловсруулалтыг ахиулах тусам бид малчдаас авах ноолуурын үнэ тогтвортой хийгээд өсөх бололцоотой. Өнөөдөр бид нар самнасан ноолуур дэлхийн зах зээл дээр 95-115 доллар байна. Энэ чинь 1 килограмм ноолуур угаагаад самначихаар 500гр болдог гээд бодох юм бол бид малчдаас 500гр ноолуур 140 орчим мянган төгрөгөөр дундажлаад аваад байгаа. Наадхыг нь долларыг нь Монгол мөнгөнд шилжүүлэхээр 300 хэдэн

мянган төгрөг, хуваахаар 170 хэдэн мянган цаас л байгаад байгаа. Тэгэхээр өнөө бэлтгэдэг, угаадаг, самнадаг тэр хоорондох ажиллах хүч, цахилгаан, гээд энэ бүх зүйлүүд орчихоор зэрэг бол ер нь одоо байж байгаа малчдаас авч байгаа ноолуурын үнэ бол тийм бага биш үнэ болчихоод байгаа. Тэгэхээр цаашид бид самнахаас дээш боловсруулалт хийх замаар л ноолуурынхаа үнэ цэнийг өсгөх ийм бололцоо боломж байна. Дээр нь ковидын энэ 2, 3 жилд Монголын ноолуурыг Европ жинхэнэ өнөө брэнд үйлдвэрлэгч нар нь сонирхчихсон. Тэр лүүгээ гаргахын тулд бид хог хольц хялгаснаас нь ялгаж гаргах тухай л асуудал хамгийн бага үндсэндээ энэ бол боловсруулалт биш, яг нарийндаа чанарын тордолтын л үйл явц байхгүй юу. Тэгэхээр үүнийгээ бүрэн хийж гаргана л гэсэн ийм л байр суурьтай байгаа.

Т.Энхтүвшин: Туваан гишүүн тодруулах уу. Асуулт асуугаад, үг хэлж дууслаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулаад зарчмын зөрүүтэй санал хэлэх гишүүд байна уу. Зүгээр санал хэлэх гишүүд. Батлут гишүүн. Батлут гишүүний микрофоныг өгөөрэй.

Д.Батлут: Монгол Улсын төсөв яг үндсэндээ өргөн барилдаж хэлэлцэгдээд 1 сар орчмын хугацаа болж байгаа юм. Тэгээд эндээс ингээд ярианы түвшинд олон мэдээллүүд бас ил болж байна. Ингээд харахаар бид нэг шүүрэн шанага шиг төсөв л батлах гээд байх шиг байна. Ер нь энэ дээр нэг эргэлт гаргах хэрэгтэй байна. Эхний асуудалтай холбоотой санал хэлэх боломжгүй байхгүй юу. Уучлаарай, тэгвэл больё.

Т.Энхтүвшин: Туваан гишүүнтэй бас санал нэг байна. Тэгээд Улсын Их Хурлын 19 дүгээр тогтоол бол хүчин төгөлдөр байж байгаа. Засгийн газар 1 жилээр хойшлуулсан. Бид бол ямар ч байсан Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороогоороо нэг ажлын хэсэг гаргаад, үнэхээр самнахаас дээших

боловсруулалт хийх чадалтай хэчнээн үйлдвэр байна гэдгийг газар дээр нь үзье л гэж ажлын хэсгийг бас гаргаж байгаа юм. Үнэхээр үзээд 10 мянгаас дээш боловсруулалт хийж байгаа тийм хүчин чадалтай үйлдвэр байх юм бол ингээд Монгол Улсын Их Хурлын 19 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж яв гэдэг чиглэлийг л Монгол Улсын Засгийн газарт өгье гэсэн ийм байдалтайгаар ажиллаж байгаа гэдгийг хэлмээр байна.

Ингээд “Ажлын хэсгийн удирдамж батлах, ажлын дэд хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Байнгын хорооны гишүүдийн 55,6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоолын төсөл батлагдлаа. “Ажлын хэсгийн удирдамж батлах, ажлын дэд хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. Байнгын хорооны гишүүддээ бас баярлалаа.

Хурал дууссаныг мэдэгдэж байна.

12.32 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ